



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
2015

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	3
НЭГ. БАЙГУУЛЛАГЫН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА	
1.1. Чиг үүрэг, бүтэц	4
ХОЁР. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ	
2.1. Санхүүгийн зах зээлийн эрх зүйн болон зохицуулалтын орчинг боловсронгуй болгох	5
2.2. Хөрөнгө оруулагч, даатгуулагч, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах	7
2.3. Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх	7
ГУРАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
3.1. Үнэт цаасны зах зээл	10
3.2. Даатгалын салбар	14
3.3. Банк бус санхүүгийн байгууллага	17
3.4. Хадгаламж, зээлийн хоршоо	18
3.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	21
3.6. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжаа	22
3.7. Зээлийн батлан даалтын сан	23
ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАРЫН ХЯНАЛТ, БҮРТГЭЛ	
4.1. Хяналт, шалгалт	25
4.2. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох, бүртгэх	26
ТАВ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА	
5.1. Байгууллагын дотоод үйл ажиллагаа	27
5.2. Хамтын ажиллагаа	27
5.3. Төсөв, санхүү	28
ЗУРГАА. 2015 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД	
ДОЛОО. 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ	
ХАВСРАЛТУУД	
Хавсралт 1. Санамж бичгийн хүрээнд хамтран ажиллаж буй байгууллагудын жагсаалт	33
Хавсралт 2. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн судалгаа	34
Хавсралт 3. 2015 онд баталсан журам, зааврын жагсаалт	35

ӨМНӨХ ҮГ



Санхүүгийн зохицуулах хороо үүсэн байгуулагдсаны 10 жилийн ой тохиосон 2015 оны үйл ажиллагааны тайланг Та бүхэнд өргөн барьж байна.

2015 онд бид Монгол Улсын санхүүгийн салбарын урт хугацааны хөгжлийн бодлогыг тодорхойлох зорилт тавин ажилласнаар "Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн төслийн баримт бичгийг боловсруулж, салбарын мэргэжилтийд гэргүүлэхэд оролцогч, судлаачид, гадаадын болон олон улсын байгууллагын төлөөлөгчдийг хамруулсан "Санхүүгийн зах зээлийн хөгжлийг" үндэсний форумд уг хөтөлбөрийн төслийг хэлэлцэн, улмаар Монгол Улсын Их Хуралд өргөн барьсан нь онцлох үйл явдал байв.


Гадаад, дотоод хамтын ажиллагаа, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн хувьд бодит ахиц дэвшил бүхий үр дүнтэй жил боллоо.

Тухайлбал, гадаад хамтын ажиллагааны хүрээнд ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн "Бага, дунд орлоготой иргэдэд зориулсан даатгалын зах зээлийн зохицуулалтыг сайжруулах зорилго бүхий бус нутгийн хөтөлбөр"-ийн хүрээнд хүртээмжтэй даатгалын 2 шинэ бүтээгдэхүүнийг бүртгэнсээр даатгалын борлуулалтын суваг өргөжиж, даатгалын хамралт нэмэгдэх нөхцөл бүрдсэн, Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны агентлагийн "Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд дотоодын компаниудын үнэт цаас олон нийтд санал болгон гаргах, давхар бүртгэлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, эрсдэл сууринсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх, Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газрын "Санхүүгийн салбарын чадавхийг бэхжүүлэх, сургалтын төсөл"-ийн хүрээнд даатгалын компаниудад өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварыг үнэлэх аргачлалыг нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтын сан, үүсмэл үнэт цаасны зохицуулалтын орчныг бүрдүүлэх, хянан шалгачийн гарын авлагыг боловсруулах зэрэг ажлуудыг дурьдах болох юм.

Иргэн, хуулийн этгээдэд холбогдох зөвлөгөөг тухай бүр өгөх, баримт бичгийн бүрдлийг хянах "Нэг цонхны үйлчилгээ"-г нэвтрүүлснээр иргэд, хуулийн этгээдэд санхүүгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох, бүртгэх үйлчилгээг түргэн, шуурхай, ил тод, чирэгдэлгүй хүргэх нөхцлийг бүрдүүлсэн ба цахим үйлчилгээний оновчтой тогтолцоог бий болгож, бүртгэл мэдээллийн нэгдсэн програм хангамжийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажилласнаар бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд буй мэдээллийг цахим байдлаар хүлээн авдаг болсон зэрэг үр дүнтэй, амжилт дагуулсан жил болж өнгөрлөө.

Хороо нь Сангийн яам, "Монголын хөрөнгийн бирж" ХК-тай хамтарч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд санхүүгийн зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдэд нэлээдгүй нааштай хандлага гарсны нэг нь Хөрөнгийн биржээр арилжаансан Засгийн газрын үнэт цаасны арилжаа 2015 онд 400.0 гаруй тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 11.0 дахин нэмэгдэж, үнэт цаасны зах зээлийн хөгжилд томоохон дэвшил авчирсан үйл явдал болсныг дурьдах нь зүйтэй.

Хороо цаашид "Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүн туршлага, стандартад нийцсэн тогтвортой үйл ажиллагаа бүхий санхүүгийн салбарыг хөгжүүлэх" эрхэм зорилгын хүрээнд өнгөрсөн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлуудаа бататгаж, ололт амжилтаа ахиулахын төлөө хичээл зүтгэл гарган ажиллах болно.

Хүндэтгэсэн,

Э.Батболд

Санхүүгийн зохицуулах хорооны даргын үүргийг гүйцэтгэгч

НЭГ. БАЙГУУЛЛАГЫН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА


1.1. ЧИГ ҮҮРЭГ, БҮТЭЦ

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага.

Хороо анх байгуулгдахдаа үнэт цаас, даатгалын салбар болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршодын үйл ажиллагааны чиглэлээр холбогдох хуулиудад заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж байсан бол шинэ тутам үүсэн бий болж буй зах зээлийн харилцаанаас шалтгаалан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай, Зээлийн батлан даалтын сангийн тухай, Малын индексжүүлсэн даатгалын тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай ээрэг хуулиудын зохицуулалтын хүрээний санхүүгийн

шинэ харилцаа Хорооны зохицуулалтад хамрагдах болсон. 2015 онд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, эрсдэлд сууринсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх болон зах зээлийг дэмжих чиглэлээр нэгдсэн бодлого, эрсдэлийн удирдлага, бүртгэл, зөвшөөрөл, зохицуулалтын оновчтой тогтолцоог бий болгох тэргүүлэх зорилтын хүрээнд Хорооны бүтцийг шинэчлэн баталснаар Зах зээлийн хөгжлийн газар, Үнэт цаасны зохицуулалтын газар, Даатгалын зохицуулалтын газар, Бичил санхүүгийн зохицуулалтын газар, Хяналт шалгалтын газар, Бүртгэл зөвшөөрлийн газар, Тамгын газар гэсэн 7 газар, Хорооны даргын дэргэдэх Дотоод аудитын хэлтэс болон Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн ажлын албатайгаар үйл ажиллагаагаа явууллаа.

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ХОЁР. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ

2.1. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

ЭРХ ЗҮЙН НИЙТЛЭГ ОРЧИН

Санхүүгийн зах зээлийн бүтцийг олон тулгуур бүхий, зохистой болгох, чөлөөт өрсөлдөөний орчныг бүрдүүлэх, санхүүгийн олон төрлийн бүтээгдэхүүн бий болгох, зуучлалыг гүнзгийрүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх "Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлээд байна.

Санхүүгийн үйлчилгээний тухай, Санхүүгийн хяналт, зохицуулалтын тухай, Санхүүгийн чөлөөт бүсийн тухай хуулийн төслүүдийг шинээр боловсруулан Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүллээ.

Зөрчлийн тухай, Хөдлөх эд хөрөнгийн болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай болон Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэгт орж салбарын асуудлаар санал дүгнэлт өгч ажиллалаа.

Мөн Хөгжлийн банкны тухай, Аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдэд санал боловсруулж, холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлэв.

ЗОХИЦУУЛАЛТЫН НИЙТЛЭГ ОРЧИН

Салбарын хэмжээнд мөрдөгддөг хууль тогтоомжуудад нийцүүлэн 20 журам шинээр, 10 журам шинэчлэн, 8 журамд нэмэлт өөрчлөлт, 2 журамд нэмэлт, 9 журамд өөрчлөлт оруулан баталж, 16 журмыг хүчингүй болгов.

Хорооноос баталсан журмууд нь бичил санхүү, даатгал, үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх, шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх, санхүүгийн зах зээлд оролцогчдод тавигдах шаардлагыг өндөржүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, зах зээлийн эрсдэлийг бууруулах, үндэсний болон гадаадын хөрөнгө оруулагчдын зах зээлд оролцох сонирхлыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох, бүртгэлийн баримт бичгийг цахим хэлбэрээр авах, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, эрх олгох, бүртгэхтэй холбоотой багц журмуудыг цэгцлэх ажлыг эхлүүлэв.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт саарсан, эдийн засгийн суурь үзүүлэлтүүд буурсан, бодит секторын бизнесийн үйл ажиллагааг агшсан өнөөгийн нөхцөл байдалд санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа эрхэлж

байгаа зохицуулалттай этгээд, мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагааг бодлогын түвшинд дэмжих, санхүүгийн нэмэлт дарамт учруулахгүй байх зорилгоор Хорооны зохицуулалтын үйлчилгээний хөлсний хувь хэмжээг бууруулах бодлого барьж ажиллалаа. Энэ хүрээнд "Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоож, тэдгээрийг төвлөрүүлэх журам"-ыг баталлаа. Үүнд:

Даатгалын салбарын хувьд даатгагчаас жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шаталгайгээр өмнөх жилийн тайланд тусгагдсан даатгалын цэвэр хураамжийн орлогын дүнгээс 0.65 хувиар төвлөрүүлдэг байсан бол 0.5 хувь болгож бууруулсан. Мөн зохицуулалтын үйлчилгээний хөлсний доод хэмжээг 3.0 сая төгрөг, дээд хэмжээг 75.0 сая төгрөг байхаар тогтоосон. Урт хугацааны болон давхар даатгалын үйл ажиллагаанаас жил бүр төвлөрүүлэх хөлсийг 5.0 сая төгрөг байсныг 3.0 сая төгрөг болгож бууруулсан бол даатгалын хохирол үнэлгээчээс жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг хохирол үнэлгээний орлогын 0.55 хувиар тооцдог байсныг 0.45 хувь болгож бууруулсан. Даатгалын байгууллагуудаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт оруулнаар даатгалын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжихээс гадна даатгалын компани, даатгалын хохирол үнэлгэч, даатгалын зуучлагч байгууллагуудыг орон нутагт мэргэжлийн үйл ажиллагаа явуулахыг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагааны зардлын тодорхой хувийг бууруулах боломж бүрдэх юм. Тухайлбал, даатгалын байгууллагын зохицуулалтын үйлчилгээний хөлсөнд төлдөг хэмжээ 30 орчим хувиар буюу 200.0 гаруй сая төгрөгөөр буурч, энэ хэмжээгээр даатгалын байгууллагын ашигт ажиллагаанд эерэгээр нөлөөлөх юм.

Үнэт цаасны зах зээлийн хувьд брокер, дилерийн компанийн хувьцааны арилжааны хэлцэл тус бүрийн үнийн дүнгийн 0.04 хувь, хувьцаанаас бусад үнэт цаасны арилжааны хэлцлээс олсон шимтгэлийн орлогын 10 хувь, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх жилийн хураамж 2.0 сая төгрөг, үнэт цаасны арилжаа эрхлэх, төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэхэд үнэт цаасны биржийн арилжааны хэлцлийн үнийн дүнгээс зохицуулалттай этгэдүүдийн авсан шимтгэлийн орлогын 10.0 хувийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тус тус 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл чөлөөлөөд байна. Ингэснээр үнэт цаасны

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2015

зах зээлийн мэргэжлийн оролцогчид зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс 2 жилийн хугацаанд бүрэн чөлөөлөгдж, үйл ажиллагааны зардлаа хэмнэх боломжтой болсон.

Хорооны зүгээс үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдын шимтгэл, хураамжийг бууруулах чиглэлийг барьж ажилласнаар "Монголын хөрөнгийн бирж" ХК-аас хувьцааны арилжааны шимтгэл 0.4 хувиас 0.15 хувь болон буурлаа.

Банк бус санхүүгийн байгууллага нь Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны гишүүн бол зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс 10 хувийн хөнгөлөлт, хадгаламж, зээлийн хоршооны нийт актив буюу хөрөнгийн дүн нь 300.0 сая төгрөгөөс доош бөгөөд Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооны гишүүн бол жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс чөлөөлөгдхөөр шийдвэрлэлээ. Мөн 300.0 сая төгрөгөөс дээш актив хөрөнгөтэй, холбооны гишүүн хадгаламж, зээлийн хоршоодод жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс 10 хувийн хөнгөлөлт эдлэх зохицуулалтыг тус тус хийсэн.

Түүнчлэн, санхүүгийн зах зээлийн мэргэжлийн бусад холбоодын үйл ажиллагааг дэмжих, өргөжүүлэх, гишүүнчлэлийг нэмэгдүүлэх, улмаар тэдгээрийн зах зээлд гүйцэтгэх үүргийг бэхжүүлж, чадавхижуулан Өөрийгөө зохицуулах байгууллага бий болгох хөшүүргийг бүрдүүлэх зорилгоор Хорооны зохицуулалт бүхий этгээд нь Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбоо, Монголын даатгалын хохирол үнэлэгчдийн холбоо зэрэг мэргэжлийн холбооны гишүүнээр элссэн тохиолдолд зохицуулалтын үйлчилгээнийн хөлс шимтгэлээс 10 хувийн хөнгөлөлт эдлэхээр боллоо.

Зохицуулалтын үйлчилгээний бусад төрлийн хөлсийг дараах байдааар бууруулав. Үүнд: Зохицуулалттай этгээдийн оноосон нэрийг өөрчлөхөд төлж байсан 2.0 сая төгрөгийг 0.5 сая төгрөг, тусгай зөвшөөрлийг сэргээхэд 0.5 сая төгрөг байсан зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 0.1 сая төгрөг болгон бууруулаа.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

"Үнэт цаасны бүртгэлийн журам"-ыг шинэчлэн баталж, нийтд санал болгон хувьцаа, бонд гаргахтай холбоотой зарим хяналтын чиг үүрэг болон бүртгэлтэй холбоотой шалгур, шаардлага тогтоох эрхийг арилжаа эрхлэх байгууллагад шилжүүллээ.

"Кастодианы санхүүгийн тайлагнал бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх заавар", "Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, цэвэр хөрөнгийгүнэлэх заавар", "Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих тухай журам"-үүдүг шинээр, "Хувьцааг компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны тухай журам", "Зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх тухай журам"-үүдүг шинэчлэн, "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулж тус тус батлав.

"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн талаар авах арга хэмжээний тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, Засгийн газарт нэрлэсэн үнэр худалдах хүсэлт гаргасан боловч хувьцааны төлбөр авч чадаагүй буюу хишиг хувь хүртээгүй 1,503,984 иргэнд 1,583,628,456 ширхэг хувьцааг буцаан эзэмшигчдийн бүртгэлийн үзүүлэлтээ.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2015 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 292 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагааны тухай асуудлыг тус тус хэлэлцүүлж, 02 тоот зөвлөмж, 2015 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн Засгийн газрын 147 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Уг шийдвэрийн үр дүнд үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн байгууллага болох арилжааны тооцооны төв байгуулагдах нөхцөлийг бүрдүүлээд байна.

ДААТГАЛЫН САЛБАР

Даатгалын үйл ажиллагаа болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох зохицуулалтыг нэгтгэж "Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам"-ыг баталлаа.

Даатгалын компанийд мөрдөгдөх "Нягтлан бодох бүртгэлийн заавар"-ыг нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлж, шинэчлэн батлав. Мөн даатгалын компанийн нөөц сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын санд байршуулах боломжийг нэмэгдүүлж, банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах хэмжээг 5.0 хүртэл хувь байсныг 20.0 хувь болгон нэмэгдүүлэв.

Ердийн болон урт хугацааны даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийх, төлбөрийн чадварын холбогдох журмуудад өөрчлөлт оруулж, нөөцийн сангаас хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулах зохицуулалтыг бий болгосноор даатгагчдын ашигт ажиллагаа нэмэгдэх боломжийг бүрдүүллээ. "Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн журам"-д нэмэлт өөрчлөлт оруулан мэдээллийн сангийн найдвартай, аюулгүй ажиллагаа, мэдээллийн нууцлал, хадгалалт, хамгаалалт, мэдээллийн сангийн холбогдох програм хангамжийн хэрэглэгчийн нэвтрэх эрх, эрхийн хязгаарлалт, хамгаалалтын түвшин, хүлээх хариуцлагыг тодорхой болгов.

"Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам", "Дамжин өнгөрөх болон тур хугацааар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам", "Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний даатгуулагчийн мэдүүлгийн маяг"-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан. 2015 онд Замын-Үүд, Ульхан, Бургастай, Тэс, Шивээхүрэн, Арцсуурь, Байтаг, Эрээнцав, Гашуунсухайт, Цагааннуур, Хавирга, Ханх, Булган, Боршоо, Ханги, Даян, Алтанбулаг, Бичигт, Баянхошуу зэрэг хилийн 19 боомтод жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа явагдлаа. Монгол Улсын хилээр дамжин өнгөрч байгаа болон тур орж ирж

байгаа гадаадын жолооч иргэдийг жолоочийн даатгалд хамруулах болсноор гадаад, дотоодын иргэдийн амь нас, эд хөрөнгөнд учруулсан хохирлыг даатгагчаар барагдуулах тогтолцоо бүрдлээ.

Даатгалын нийт 16 компанийн даатгалын гэрээнүүдийг цахим хэлбэрт оруулж, даатгалын гэрээний мэдээллийн санг бүрдүүлсэн.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагааг зохицуулж байсан 4 журам, 1 зааврыг нэгтгэн "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ыг шинэчлэн баталлаа.

Мөн "Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам"-ыг шинэчлэн, Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам", "Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-уудыг шинээр баталлаа.

Хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаанд бий

болж болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс "Бичил бизнесийг дэмжих ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж байгаа хадгаламж, зээлийн хоршоодын зохистой харьцааны үзүүлэлтүүдийг "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгур үзүүлэлт болон дагаж мөрдөх үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах замаар шинэчлэн тогтоолоо.

"Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр"-ийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, хадгаламж, зээлийн хоршоодын чадавхийг бэхжүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллахаар Нийслэлийн Засаг даргатай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, Хорооноос нийт 114 хадгаламж, зээлийн хоршоонд төсөл, хөтөлбөр дамжуулан хэрэгжүүлэх зөвшөөрөл олголоо. Үүний үр дүнд Нийслэлийн 130 хорооны 101 хадгаламж, зээлийн хоршоогоор дамжуулж, 10.6 тэрбум төгрөгийн хямд өртөг бүхий урт хугацааны санхүүжилт 2,712 бичил бизнесийн төсөлд олгосноор 7,600 ажлын байрыг шинээр бий болгосон байна

2.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ДААТГУУЛАГЧ, ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ

Хяналт, шалгалтын газарт иргэд, аж ахуйн нэгжээс Хорооны зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой 389 өргөдөл ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэлээ.

ҮНЭТ ЦААС

Үнэт цаасны зах зээлд оролцогчидтой холбоотой нийт 159 өргөдөл ирснээс хувьцаат компанийн үйл ажиллагаа, ногдол ашиг болон үнэт цаасны бүртгэлтэй холбоотой 58, хөрөнгө оруулалтын эрхийн бичигтэй холбоотой 101 өргөдөл ирсэн байна.

Эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр худалдсантай холбоотой хохирол барагдуулах чиглэлээр 24.7 сая төгрөгийн төлүүлэхээр буруутай этгээдэд үүрэг болголоо.

ДААТГАЛ

Иргэн, аж ахуйн нэгжээс даатгалын компанийн үйл ажиллагаатай холбоотой нийт 184 өргөдөл ирүүлснийг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн ба нийт 168.5 сая

төгрөгийн хохирлыг барагдуулан ажиллалаа. Эдгээр нийт өргөдлийн 41.0 хувийг тээврийн хэрэгслийн даатгал, 35.0 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, 24.0 хувийг бусад даатгалын төрлүүдтэй холбоотой өргөдөл тус тус эзэлж байв.

Авто тээврийн хэрэгслийн даатгалын гэрээнд тусгагдсан даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөлийг Хорооны болон тухайн компанийн цахим хуудаст байршуулснаар даатгалын гэрээтэй холбоотой мэдээлэл ил тод болгов.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Тайлант хугацаанд банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаатай холбоотой иргэн, аж ахуйн нэгжүүдээс нийт 46 өргөдөл ирснээс 58.7 хувь нь хадгаламж, зээлийн хоршоо, 41.3 хувь нь банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл эзэлж байна

2.3. ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ

"Олон нийтийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр 2016-2021"-ийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн ба Монголбанкны өрөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны сайдын хамтарсан тушаалаар батлууллаа. Хөтөлбөрийн хүрээнд 2016 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулах, хөтөлбөрийн ач холбогдлыг олон нийтэд

таниулах, ажлын хэсгүүдийг байгуулах зэрэг ажлуудыг Монголбанктай хамтран гүйцэтгэв.

"Санхүүгийн үйлчилгээний хүртээмж ба орон нутгийн хөгжил" бус нутгийн чуулга уулзалтыг Завхан, Хэнтий аймгуудад тус тус зохион байгуулсан ба "Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн төслийг зах зээлд оролцогч, мэргэжлийн

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2015

байгууллагуудад танилцуулах хэлэлцүүлэг, "Санхүүгийн зах зээлийн үндэсний анхдугаар форум"-ыг тус тус зохион байгууллаа. Форумд төр засгийн болон санхүүгийн зах зээлд оролцогч байгууллагуудын 400 гаруй төлөөлөгч хамрагдлаа.

Зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдүүлэхээр шинээр болон шинэчлэн боловсруулсан журам, заавар, аргачлал, бусад эрх зүйн хэм хэмжээг мэргэжлийн холбоод, зохицуулалтын байгууллагуудад танилцуулах зорилгоор сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг тухай бүр зохион байгуулан ажилласан.

Хорооноос гарч буй шийдвэр болон санхүүгийн зах зээлийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх ажлын хүрээнд олон нийтийн хэвлэл мэдээллийн 15 телевиз, 1 радио, 2 мэдээллийн агентлаг, 6 өдөр тутмын сонин, 1 сэтгүүл, 18 цахим хуудастай хамтран ажиллалаа. Мөн санхүүгийн зах зээлийн талаарх мэдээ, мэдээлэл бүхий "Mongolian Finance" сэтгүүлийн анхны дугаарыг эрхлэн гаргаж, олон нийтийн хүртээл болголоо.

2015 оны улирал тутмын бүлжилтэй гаргасан ба статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn цахим хуудсанд санхүүгийн зах зээлийн мэдээллийн бүтэц агуулгыг шинэчилсэн.

Гадаад, дотоодын санхүүгийн зах зээлийн 7 хоног, сар, улирал тутмын тойм мэдээллийг тогтмол гаргаж хэвшлээ.

ҮНЭТ ЦААС

Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлд заасан 11 компанийн хувьчлалтай холбоотойгоор компанийн засаглал, гадаад болон дотоодын зах зээлд үнэт цаас гаргах болон бүртгэлтэй компанийн дагах мөрдөх шаардлагатай дүрэм, журмын зохицуулалтын талаар "Үнэт цаасны бүртгэл", "IPO болон Давхар бүртгэл" зэрэг сэдвүүдээр нийт 4 удаагийн сургалт, семинарыг Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны агентлагийн "Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл", Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Төрийн өмчийн хороотой хамтран зохион байгууллаа. Компанийн эрх бүхий албан тушаалтанд зориулсан эдгээр сургалтуудад нийт 300 гаруй оролцогчид хамрагдav.

Мөн Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны агентлагийн "Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл"-ийн багтай хамтран "Өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагааны зохицуулалт", Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газрын "Санхүүгийн салбарын чадавхийг бэхжүүлэх, сургалтын төсөл"-ийн дэмжлэгтэйгээр хөрөнгө оруулалтын сан, үүсмэл үнэт цаасны чиглэлээр зах зээлд оролцогчдыг хамруулсан сургалтуудыг тус тус зохион байгууллаа.

Банк санхүүгийн академитай хамтран "Хөрөнгө оруулалтын сангийн мэргэшсэн сангуудыг хөгжүүлэх нь" нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж, "Үнэт цаас гаргах замаар хөрөнгө татан төвлөрүүлэх боломж, бололцооны талаар хувьцаат компаниудын улс орны нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө" сэдвээр Ийгл телевизийн "Боломж сонголт", Хорооны дэргэдэх Үнэт цаасны бодлогын зөвлөл,

мэргэжлийн холбоо, үнэт цаас гаргагчдын төлөөллийг оролцулсан "Хувьцааны төвлөрөл" сэдвээр 9:1 нэвтрүүлэгт тус тус оролцов.

Олон нийтийн санхүүгийн боловсролд зориулан "Иргэн та-хувьцаа эзэмшигч", "Иргэн та- хөрөнгө оруулагч", "IPO-таний компанийн санхүүгийн шийдэл", "Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцох", "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас", "Хөрөнгө оруулалтын сан" зэрэг нийт 6 брошур бэлтгэж, гарын авлагыг болгон хэвлүүллээ.

Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх олгох шалгалтыг 3 удаа зохион байгуулж, нэгдсэн дунгээр үнэт цаасны зуучлалын чиглэлээр 41, хөрөнгө оруулалтын чиглэлээр 74, буюу нийт үнэт цаасны зах зээлд ажил, үйлчилгээ явуулах эрхийг 115 мэргэжилтэнд олгож, 38 мэргэжилтэн эрх сунгуулсан бөгөөд мэргэжилтнүүдийн бүртгэлийг мэдээллийн санд оруулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

ДААТГАЛ

Нийслэл, 21 аймагт Монголын даатгагчдын холбоотой хамтран даатгалын төлөөлөгчийн сургалтыг зохион байгуулж, 837 оролцогчоос шалгалт авснаас, 733 оролцогч шалгалтад тэнцсэн. Мөн Монголын даатгалын зуучлагчдын холбоотой хамтран зохион байгуулсан даатгалын зуучлагчийн сургалтад Хас банк, Хаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк болон нэр бүхий даатгалын зуучлагч компаниудын 124 ажилтан, албан хаагч хамрагдаж, шалгалт егснөөс 105 нь тэнцсэн байна.

Монголын хохирол үнэлэгчдийн холбоотой хамтран зохион байгуулсан "Даатгалын хохирол үнэлэгчийн анхан шатны мэдлэг олгох сургалт", Банк санхүүгийн академиас даатгалын зуучлагч банкуудын ажилтнуудыг хамруулсан "Даатгалын зуучлагчийн эрх олгох сургалт"-уудад мэргэжлийн хичээл зааж, шалгалтын тест боловсруулан шалгалт авлаа.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийт 6 удаа Монголын даатгагчдын холбоо, Монголын актуарчдын нийгмэлэг, Монголын албан журмын даатгагчдын холбоо, Монголын хохирол үнэлгээчдийн холбоо, Монголын даатгалын зуучлагчдын салбарын мэргэжлийн холбоодтой уулзалтыг тус тус зохион байгуулж, санал солилцсон ба холбоодын зохион байгуулсан сургалтын үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллав.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Улаанбаатар хотод шинээр байгуулагдсан хадгаламж, зээлийн хоршоодын чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан ба уг сургалтад нийт 88 хадгаламж, зээлийн хоршоодын 177 ажилтан, сонгуульт албан тушаалтан болон Бичил бизнесийг дэмжих Нийслэлийн сангийн 5 ажилтан хамрагдсан. Мөн орон нутгийн 41 хадгаламж, зээлийн хоршоодод бойжуулах сургалтыг хоршооны сургагч багш, Азийн Хөгжлийн Банкны "Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх" төслийн багтай хамтран зохион байгууллаа.

Азийн Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд "Интерактив Би Ай" ХХК-тай хамтран тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй нийт хадгаламж, зээлийн хоршоодыг удирдлагын мэдээллийн нэгдсэн системд холбох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү арга хэмжээний хүрээнд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодод зориулсан нягтлан бodoх бүртгэлийн програмыг үнэ төлбөргүй нэвтрүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд уг програмыг нэвтрүүлэх сургалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгууллаа. Хөдөө орон нутгийн хадгаламж, зээлийн хоршоодод зориулсан сургалтыг баруун, зүүн, төв,.govийн бус гэж ангилан Уvs, Хэнтий, Орхон, Дундговь аймгуудад хийж 71 хадгаламж, зээлийн хоршооны нягтлан бодогчид хамрагдаж тэдний албан хэрэгцээнд нь зориулсан зөөврийн компьютер болон нягтлан бodoх бүртгэлийн програмыг хүлээлгэн өгсөн бол Улаанбаатар хотод З ээлжээр зохион байгуулсан сургалтад 100 хадгаламж, зээлийн хоршооны 119 ажилтан, нийт 171 хадгаламж, зээлийн хоршооны 200-аад ажилтан хамрагдаад байна. Энэхүү програмыг нэвтрүүлснээр удирдлагын мэдээллийн нэгдсэн систем бий болохын зэрэгцээ Хороонд ирүүлэх санхүүгийн тайлан, холбогдох бусад мэдээ, мэдээллийг богино хугацаанд гаргах, хадгаламж, зээлийн хоршоодын санхүүгийн сахилга бат, үйл ажиллагааны дотоод хяналт, хариуцлага сайжрах юм. Мөн салбарын санхүүгийн нэгдсэн мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах, мэдээлэл түргэн шуурхай солилцох, хадгаламж, зээлийн хоршоодын ажлын хэрэгцээний техникийг шинэчлэх, Хорооноос хэрэгжүүлж байгаа хяналт шалгалтын үр дүнг сайжруулах зэрэг ач холбогдолтой юм.

Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой хамтран зохион байгуулсан 10 удаагийн сургалтад 90-ээд банк бус санхүүгийн байгууллагын 550 ажилтан хамрагдсан байна.

Мөн Азийн Хөгжлийн Банкны төсөл, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоотой хамтран "Сайн туршлага-хөгжлийн үндэс" сэдэвт өдөрлөгийг Архангай аймагт зохион байгуулсан ба нийт 9 аймгийн 32 ХЗХ-дын 57 ажилтан, сонгуульт албан тушаалтан хамрагджээ.

Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, иргэдэд санхүүгийн боловсрол олгох, санхүүгийн зах зээлийн талаар ээрэг ойлголтыг бий болгох зорилгоор өдөр тутмын сонин болох Өдрийн сонинд 5 удаагийн нийтлэл гаргах, Ийгл телевизийн "Боломж сонголт" цуврал нэвтрүүлгээр хадгаламж, зээлийн хоршоо болон банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны талаарх нэвтрүүлгийг бэлтгэх, Үндэсний шуудан сонинд хадгаламж, зээлийн хоршоодын гишүүдийн ярилцлагыг хэвлэн нийтлүүлэх, Олон улсын Санхүүгийн хүрээмжийн нийгэмлэгээс гаргадаг сэтгүүлд бичил санхүүгийн өнөөгийн байдал, тус нийгэмлэгийн санхүүжилтээр хэрэгжсэн төслийн үр дүнгийн талаар мэдээлэл бэлтгэх, Боловсрол телевизтэй хамтран хадгаламж, зээлийн хоршоодын талаар хэлэлцүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулж ажиллалаа. Мөн "Бичил санхүү", "Та хадгаламж, зээлийн хоршооны гишүүн бол" брошуруудыг олон нийтийн хүртээл болгов.


ГУРАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

3.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ

2015 оны эцсийн байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 1,26 их наяд төгрөг болов.

Дүрслэл 1. Зах зээлийн үнэлгээ (их наяд төгрөг)



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, үл хөдлөх хөрөнгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын зах зээлийн үнэлгээ өсөлттэй гарсан хэдий ч уул уурхай, барилга угсралт, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын хувьцааны ханшийн уналт зах зээлийн үнэлгээний бууралтад голлоо нөлөө үзүүлсэн.

Тайлант хугацааны зах зээлийн үнэлгээг ДНБ-ий урьдчилсан гүйцэтгэлд харьцуулан тооцоход 5.5 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Дүрслэл 2. Зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, эдийн засгийн өсөлт



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

Хороо, "Монголын хөрөнгийн бирж" ХК болон "ҮЦТТХТ" ХХК-д бүртгэлтэй үнэт цаас гаргагчдын тоог харуулбал:

Хүснэгт 1. Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо

Үнэт цаасын гаргагчийн өмчийн хэлбэр	Санхүүгийн зохицуулах хороо	"Монголын хөрөнгийн бирж" ХК	"ҮЦТТХТ" ХХК
Төрийн өмчтэй	32	21	22
Төрийн болон орон нутгийн оролцоотой	25	16	24
Хувийн өмчтэй	242	198	273
Нийт	299	235	319

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Хорооны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл нь хувьцаат компанийн үндсэн бүртгэл бөгөөд үнэт цаасны зах зээлд бүртгэлтэй нийт компанийн тоог илтгэдэг.

"Монголын хөрөнгийн бирж" ХК нь үнэт цаасны бүртгэлийн шалгуур хангаж ажиллаагүй нэр бүхий 57 хувьцаат компанийн үнэт цаасыг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн бүртгэлээс хассан.

Энэ хүрээнд хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлагыг хангаж үнэт цаасны арилжаагаа сэргээх хүсэлтээ ирүүлээгүй компаниудыг биржийн бүртгэлээс хасах болон албадан татан буулгах, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлж ирлээ.

Хороо хөрөнгө оруулагчдыг хамгаалах, биржийн бүртгэлийг олон улсын нийтлэг жишигт хүргэх зорилгын хүрээнд хувьцаат компаниудад шалгалт хийж, үйл ажиллагаа нь зогссон, өмч хөрөнгө нь үргэдсэн, хувьцаа эзэмшигчдийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй нэр бүхий 165 хувьцаат компанийн үнэт цаасны арилжааг 2008 оны 77 дугаар тогтоолоор зогсоож, Компанийн тухай болон


Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар хүлээсэн үүргээ хангаж ажиллаагүй нэр бүхий 57 хувьцаат компанийн үнэт цаасыг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн бүртгэлээс хассан.

Хороо хөрөнгө оруулагчдыг хамгаалах, биржийн бүртгэлийг олон улсын нийтлэг жишигт хүргэх зорилгын хүрээнд хувьцаат компаниудад шалгалт хийж, үйл ажиллагаа нь зогссон, өмч хөрөнгө нь үргэдсэн, хувьцаа эзэмшигчдийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй нэр бүхий 165 хувьцаат компанийн үнэт цаасны арилжааг 2008 оны 77 дугаар тогтоолоор зогсоож, Компанийн тухай болон

ХӨРВӨХ ЧАДВАР

Үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадварыг нийт арилжигдсан хувьцааны үнийн дүнг зах зээлийн үнэлгээ, ДНБ-д харьцуулан тооцов. Тайлант хугацаанд "Монголын хөрөнгийн бирж" ХК-аар нийт 125 компанийн 35.8 сая ширхэг хувьцаа 30.5 тэрбум төгрөгөөр арилжаалагдсан ба үүнийг зах зээлийн үнэлгээнд харьцуулан тооцоход 0.024 нэгж буюу 2.4 хувь, ДНБ-д харьцуулахад 0.1 хувьтай тэнцэж байна.

Дүрслэл 3. Үнэт цаасны хөрвөх чадвар



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

ХУВЬЦААНЫ ТӨВЛӨРӨЛ


Тайлант хугацаанд зах зээлийн үнэлгээний 88.4 хувийг нэр бүхий 30 компани бүрдүүлсэн бөгөөд эдгээр компаниуд нь 2005 оноос хойш үнэт цаасны зах зээлд шинээр болон нэмж үнэт цаасаа олон нийтэд арилжаалсан, эсхүл уул уурхай, аж үйлдвэрийн үндэсний томоохон аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл юм.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид нийт 804.9 мянган иргэн, аж ахуйн нэгжийн данс бүртгэлтэй байгаагаас арилжаанд давхардсан тоогоор 10 орчим мянган харилцагч идэвхитэй оролцсон байна. 1,049 хувьцаа эзэмшигч бүртгэлтэй компаниудын 5-аас дээш хувийг эзэмшиж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2015

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж дахь хувьцааны төвлөрлийг үзүүлбэл:

Дүрслэл 4. Хувьцааны төвлөрөл




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид тухайн үнэт цаасны 5-аас дээш хувийг 1,049 хувьцаа эзэмшигч эзэмшиж байгаа нь нийт хувьцаа эзэмшигчдийн 2 хувийг эзэлж байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 15,737.2, дундаж үзүүлэлт 12,477.3, доод үзүүлэлт 11,962.1 нэгж байлаа. 2015 оны жилийн эцсийн ТОП-20 индексийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.2 хувиар буурч, 12,897.6 нэгж болжээ.

Дүрслэл 5. ТОП-20 индекс




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

"Монголын хөрөнгийн бирж" ХК нь 2015 оны 2 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн MSE ALL индексийг албан ёсоор тооцож эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд тус

индексийн дээд үзүүлэлт 1,057.9, доод үзүүлэлт 854.8, дундаж үзүүлэлт 953.3 нэгж байв.

Дүрслэл 6. MSE ALL индекс




Эх үүсвэр: "Монголын хөрөнгийн бирж" ХК

Хувьцааны арилжаа

Тайлант хугацаанд "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн нийт 252 өдрийн арилжаагаар 125 хувьцаат компанийн 35.8 сая ширхэг хувьцааг 30.5 тэрбум төгрөгөөр арилжаалагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.2 тэрбум төгрөг буюу 25.7 хувиар ёсчээ.

Хувьцааны арилжааны хэмжээ 2012 оноос хойш тасралтгүй буурах хандлагатай байсан боловч тайлант хугацаанд "МИК холдинг" ХК-ийн олон нийтэд санал болгон гаргасан 1.6 сая ширхэг 19.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий хувьцааг анхдагч зах зээл дээр арилжаалсан нь өсөлтөд нөлөөлсөн байна.

Дүрслэл 7. Хувьцааны арилжаа (тэрбум төгрөг)



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

"Монголын хөрөнгийн бирж" ХК-аар дамжуулан нийт 510.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 5.4 сая ширхэг Засгийн газрын үнэт цаасыг анхдагч зах зээл дээр арилжсан бол хоёрдогч зах зээлд 52.3 мянган ширхэг үнэт цаас 5.1 тэрбум төгрөгөөр тус тус арилжигдлаа.

КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

"Монголын хөрөнгийн бирж" ХК нь "Эрчим инженеринг" ХХК-аас олон нийтэд санал болгон гаргасан нэг бүр нь 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50.0 мянган ширхэг даатгагдсан "Эрчим" бондыг 500.0 сая төгрөгөөр арилжаалсан байна.

АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

"Бинсэ" ХК-ийн 150.8 мянган ширхэг хувьцааг 112.2 сая төгрөгөөр, "Би Ди Сек" ХК-ийн 189 ширхэг хувьцааг 405.6 мянган төгрөгөөр, "Эрчим инженеринг" ХХК-ийн 50 мянган ширхэг бондыг 500 сая төгрөгөөр, "МИК Холдинг" ХК-ийн 1.6 сая ширхэг хувьцааг 19.5 тэрбум төгрөгөөр тус тус арилжсан нь 2008 оноос хойш хугацаанд олон нийтэд үнэт цаасаа санал болгон гаргасан хамгийн өндөр үзүүлэлт боллоо.

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойших хугацаанд төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2015

нийт 804,964 данс, 135,276 холболтын данс нээгдсэнээс 800,478 нь дотоодын иргэн, 1,831 гадаадын иргэн, 2,479 дотоодын аж ахуйн нэгж, 176 гадаад аж ахуйн нэгжийн данс байна.

Тайлант хугацаанд нийт 19,101 данс нээгдсэний 18,985 нь дотоодын иргэний, 67 нь гадаадын иргэний данс, аж ахуйн

нэгжийн хувьд дотоодын 46, гадаадын аж ахуйн нэгжийн 3 данс байна. Дээрх дансын 99.0 хувийг дотоодын иргэн, аж ахуйн нэгжийн данс эзэлж байна.

Үнэт цаасны арилжаанд гадаадын иргэн, аж ахуйн нэгж 9.0 тэрбум төгрөг, дотоодын иргэн, аж ахуйн нэгж 527.4 тэрбум төгрөгийн гүйлгээг тус тус хийжээ.


3.2. ДААТГАЛЫН САЛБАР

2015 оны байдлаар ердийн 15, урт хугацааны 1 даатгалын компани, тэдгээрийн 255 салбар, Хөдөө аж ахуйн давхар даатгалын 1, даатгалын зуучлагч 37, хохирол үнэлэгч 27, даатгалын 3340 төлөөлөгч, 15 актуарч Хорооноос тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх авсны дагуу мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

НИЙТ АКТИВ

Тайлант хугацаанд давхар даатгалын болон даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 173.2 тэрбум төгрөг байгаа нь өмнөх тайлант он буюу 2014 оны 4 дүгээр улиралтай харьцуулахад 20.7 тэрбум төгрөгөөр буюу 13.6 хувиар өссөн байна. Үүнд 2015 оны 01 дүгээр сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн нийт хөрөнгийн дүн 26.1 тэрбум төгрөгт хүрсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Дүрслэл 8. Ердийн болон урт хугацааны даатгалын компаниудын нийт хөрөнгө (тэрбум төгрөг)



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт хөрөнгийн 80.0 хувийг эргэлтийн хөрөнгө эзэлж байгаа бол эх үүсвэрийн 48.0 хувийг өр төлбөр тус тус эзэлж байна.

НӨӨЦ САН

Даатгалын компаниудын нөөц сангийн хэмжээ 62.9 тэрбум төгрөгт хүрсэн нь салбарын нийт хөрөнгийн 44.3 хувийг эзэлж байна.

ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант хугацаанд нийт хураамжийн орлого 113.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 5.2 тэрбум төгрөгөөр буюу 5.0 хувиар өсчээ.


Хураамжийн орлогын хэмжээ 2008 оноос хойш тасралтгүй нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа нь сайн дурын болон албан журмын даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, нэмэгдэж, хүртээмж сайжирсантай холбоотой.

Дүрслэл 9. Даатгалын салбарын хураамжийн орлого (тэрбум төгрөг)



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 10. Давхар даатгалын хураамж (тэрбум төгрөг)



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

2015 онд даатгалын компаниуд гадаадын давхар даатгалын компанид эрсдэлээ шилжүүлсний хураамжид 42.0 тэрбум төгрөгийг төлсөн нь нийт хураамжийн орлогын 36.8 хувтай тэнцэв.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2015

ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

Салбарын хүртээмж, эрэлтийг илэрхийлэгч даатгалын нягтралын үзүүлэлтийг нийт хүн амд ногдох хураамжийн орлогын харьцаагаар тооцоход:

Дүрслэл 11. Даатгалын нягтрал



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ 37,298 төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 3.0 хувиар өсчээ. Үүнийг даатгалын ангиллаар авч үзвэл, ердийн даатгалын хураамж 36,757 төгрөг, урт хугацааны даатгалын хураамж 541 төгрөг байна.

ДААТГАЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ

Даатгалын гүнзгийрэлтийн үзүүлэлт нь тухайн салбарын эдийн засаг болон санхүүгийн зах зээлд эзлэх хувь хэмжээг илтгэх бөгөөд ДНБ-ий урьдчилсан гүйцэтгэлд харьцуулан тооцоход нийт хураамжийн орлого 0.5 хувь, активын дүн 0.6 хувийг тус тус эзэлж байна.

ДААТГАЛЫН САЛБАРЫН БҮТЭЦ


Даатгалын салбарын бүтцийг голчлон салбарын эрэлт, нийлүүлэлт, зах зээлд эзлэх хувь, оролцогчдын тоо, төвлөрөл, зах зээлд орох, гарах нөхцөл зэргээр төлөөлүүлэн үзэх ба тайлант хугацаанд ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 23 төрлийн бүтээгдэхүүнийг иргэд,

аж ахуйн нэгжүүдэд санал болгосноор өссөн дүнгээр 1,030,814 даатгалын гэрээ байгуулагдсан байна.

ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛ БОЛОН ХОХИРЛЫН ҮНЭЛГЭЭ

Тайлант хугацаанд даатгалын тохиолдлын улмаас нийт 66,012 даатгалын гэрээнд 36.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Тайлант хугацаанд “Монгол даатгал” ХХК 8.1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь хамгийн өндөр бөгөөд нийт нөхөн төлбөрийн 22.1 хувийг эзэлж байна. Даатгалын компаниудын тайлант улирлын дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн нийт нөхөн төлбөр 5.1 дахин, “Мандал женерал даатгал” ХХК-ийн нөхөн төлбөр 2.9 дахин өссөн нь компанийн тухайд өндөр өсөлтийг харуулж байгаа бөгөөд үүнд “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн автотээврийн хэрэгслийн даатгалын хэлбэрийн, “Мандал женерал даатгал” ХХК-ийн автотээврийн хэрэгслийн даатгалын болон барилга, угсралтын даатгалын хэлбэрийн нөхөн төлбөрийн огцом өсөлт тус тус нөлөөлсөн байна.

Дүрслэл 12. Даатгалын нөхөн төлбөр (тэрбум төгрөг)



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

3.3. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

НИЙТ АКТИВ

2015 оны жилийн эцэст банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-уудын нийт актив 623.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 115.2 тэрбум төгрөг буюу 18.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 13. ББСБ-ын нийт хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөг)



Нийт активын хэмжээг ДНБ-ий урьдчилсан гүйцэтгэлд харьцуулахад 2.7 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 0.5 хувиар өсчээ.

ЗЭЭЛ

Нийт зээлийн хэмжээ ДНБ-ий урьдчилсан гүйцэтгэлийн 1.7 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 0.38 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Чанаргүй зээлийн үзүүлэлт 9.8 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.5 хувиар өсөөд байна.

Дүрслэл 14. ББСБ-ын зээлийн чанар (тэрбум төгрөг)



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2015

Дүрслэл 15. ББСБ-ын тоо



Эхүүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-уудын 84.4 хувь нь зээлийн үйл ажиллагаа, 6.0 хувь нь хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 5.8 хувь нь итгэлцлийн үйлчилгээ, 4.0 хувь нь факторингийн үйлчилгээ, 3.3 хувь нь төлбөрийн баталгаа гаргах, 1.3 хувь нь цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын үйлчилгээ, 0.4 хувь нь богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээг тус тус эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

Хүснэгт 2. ББСБ-ын санхүүгийн голлох үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

Үзүүлэлтүүд	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Нийт актив	96.5	128.6	205.4	252.1	381.1	508.0	623.1
Нийт олгосон зээл	55.5	78.1	119.0	157.8	223.7	303.1	391.2
Нийт өр төлбөр	21.6	36.6	67.2	80.7	146.8	175.9	175.6
Эзэмшигчдийн өмч	74.8	92.0	138.2	171.3	234.3	332.1	424.2
Үүнээс:							
Хувьцаат катитал	66.4	80.0	116.5	137.9	183.7	258.2	308.4
Бусад өмч	0.5	0.5	3.2	7.6	7.2	7.2	12
Сангүүд	1.1	1.1	1.1	0.1	0.2	0.3	0.3
Хуримтлагдсан ашиг / алдагдал	6.1	9.4	14.7	24.2	41.7	64.0	102
Хоёрдогч өглөг	0.8	0.9	2.7	1.6	1.6	2.4	1.4
Нийт орлого	26.6	30.1	46.3	70.5	106.6	132.9	156.3
Нийт зарлага	21.7	22.9	34.9	51.9	76.8	96.5	110
Татварын дараах цэвэр ашиг	4.9	7.1	11.4	18.6	29.8	36.4	46.3

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо


3.4. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

НИЙТ АКТИВ

ДНБ-д эзлэх хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-дын нийт активын хэмжээ 0.4 хувьд хүрсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.1 хувиар өссөн байна. Нийт активын

хэмжээ 2015 оны 4 дүгээр улирлын байдлаар 97.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.1 тэрбум төгрөг буюу 21.3 хувиар өссчээ.

Дүрслэл 16. ХЗХ-дын активын өөрчлөлт



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Активын төвлөрөөр нь ангилахад, томоохон буюу 1.0 тэрбум төгрөгөөс дээш актив хөрөнгтэй 10 ХЗХ-ны нийт актив 48.5 тэрбум төгрөгт хүрсэн ба тэдгээрийн гишүүдийн тоо 4.4 мянгад хүрээд байна.

ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нийт зээлийн хэмжээ 75.3 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.8 тэрбум төгрөг буюу 22.5 хувиар өссөн. Тайлант хугацаанд ДНБ-д эзлэх нийт зээлийн хэмжээ 0.3 хувьд хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 хувиар өсчээ.

Дүрслэл 17. ХЗХ-дын зээлийн чанар (тэрбум төгрөг)




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт зээлийн хэмжээ өсөхөд тайлант хугацаанд нийт ХЗХ-дын тоо 94-өөр нэмэгдэж, нийслэлээс хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн санхүүжилт нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

ӨР ТӨЛБӨР, ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

ХЗХ-дын эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.1 тэрбум төгрөг буюу 21.3 хувиар өссөн.

Дүрслэл 18. ХЗХ-дын өр төлбөр, өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг)



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2015

ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 59.2 тэрбум төгрөг буюу нийт эх үүсвэрийн 60.7 хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 57.9 тэрбум төгрөг буюу 97.7 хувь нь хугацаатай хадгаламж байна.

Хүснэгт 3. ХЗХ-дын хадгаламжийн ангилал

№	Хадгаламжийн хэмжээ (интервалаар)	ХЗХ-дын тоо	Хадгаламжийн дүн (мянган төгрөг)	Нийт хадгаламжид эзлэх хувь	Хадгаламж эзэмшигч гишүүдийн тоо
1	10,000,000.0 дээш	1	22,568,275.7	38.1%	1,215
2	1,000,000.0-10,000,000.0	9	26,076,994.5	44.0%	3,236
3	500,000.0-1,000,000.0	2	1,143,982.2	1.9%	796
4	100,000.0-500,000.0	25	6,334,051.8	10.7%	4,136
5	50,000.0-100,000.0	19	1,402,945.9	2.4%	2,369
6	10,000.0-50,000.0	55	1,358,407.5	2.3%	3,059
7	5,000.0-10,000.0	28	184,381.3	0.3%	730
8	5,000.0 хүртэл	87	196,247.7	0.3%	1,957
9	Хадгаламжгүй	27	-	0.0%	548

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 19. ХЗХ-дын хадгаламжийн өсөлт (тэрбум төгрөг)




Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

Тайлант улиралд нийт 253 ХЗХ Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.


Дүрслэл 20. ХЗХ-дын тоо



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт 253 ХЗХ-ны гишүүдийн тоо 39,146-д хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 8,448-аар өссөн байна. Нийт гишүүдийн 18,046 буюу 46.1 хувь нь хадгаламж эзэмшигч, 18,972 буюу 48.5 хувь нь зээлдэгч гишүүд байна.

Дүрслэл 21. ХЗХ-дын ашигт ажиллагаа (тэрбум төгрөг)



Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

3.5. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан "Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамtran хэрэгжүүлэх санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгч, Барилга, хот байгуулалтын сайдын 2013 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А-2/06 тоот тушаалаар "Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтвортжуулах" дэд хөтөлбөрийг баталсан.

Энэхүү дэд хөтөлбөрт ипотекийн хоёрдогч захыг хөгжүүлэх эхний үе шатанд санхүүгийн эх үүсвэрээр хангах, ипотекийн хоёрдогч захад үйл ажиллагаа явуулах үндсэн санхүүгийн байгууллагыг бодлого зохицуулалтаар дэмжих арга, хэрэгслээр 3 жилийн хугацаанд, 800.0 тэрбум төгрөгийн санхүүжилттэй хэрэгжүүлэх "Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр" багтсан.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд 2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан "Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох талаар хамtran ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг"-т Монголбанкны эзэмшиж байгаа ипотекоор баталгаажсан үнэт цаастай тэнцэх хэмжээний

урт хугацаат үнэт цаасыг Засгийн газар эдийн засгийн чадавхид тулгуурлан нийгмийн даатгалын санг дахин хөрөнгөжүүлэх зорилгоор хэсэгчлэн гаргахаар заасан.

"МИК ОССК" ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах зорилго бүхий өөрийн бүрэн эзэмшилийн тусгай зориулалтын компаниудыг үүсгэн байгуулж, Хорооноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны болон хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл авсан байна.

Улмаар Хорооны 2015 оны 417 дугаар тогтооолоор "МИК ОССК" ХХК-д нээлттэй компани болон хэлбэрээ өөрчлөхийг зөвшөөрч, нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 20,709,320 ширхэг хувьцааг үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэсэн.

Тайлант онд тусгай зөвшөөрөл бүхий 7 тусгай зориулалтын компани нийт 47,495 зээлдэгчийн зээлийн хөрөнгөөр баталгаажсан 2,171.7 тэрбум төгрөгийн үнэ бүхий баталгаат үнэт цаас гаргаснаас 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 160.3 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр төлөгдөв.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2015

Xүснэгт 4

№	Компанийн нэрс	"ҮЦТТХХТ" ХХК бүртгэсэн	2015.12.31-ний өдрийн байдлаарх үлдэгдэл	Төлөгдсөн үндсэн төлбөр
1	"МИК актив нэг ТЗК" ХХК	Гаргасан баталгаат үнэт цаасны дүн (тэрбум төгрөг)	322.9	267.2
		Зээлдэгчдийн тоо	7,853	6,896
2	"МИК актив хоёр ТЗК" ХХК	Гаргасан баталгаат үнэт цаасны дүн (тэрбум төгрөг)	222.0	177.6
		Зээлдэгчдийн тоо	5,898	5,433
3	"МИК актив гурав ТЗК" ХХК	Гаргасан баталгаат үнэт цаасны дүн (тэрбум төгрөг)	324.6	285.0
		Зээлдэгчдийн тоо	7,059	6,747
4	"МИК актив дөрөв ТЗК" ХХК	Гаргасан баталгаат үнэт цаасны дүн (тэрбум төгрөг)	452.3	448.3
		Зээлдэгчдийн тоо	9,961	9,684
5	"МИК актив тав ТЗК" ХХК	Гаргасан баталгаат үнэт цаасны дүн (тэрбум төгрөг)	294.3	277.7
		Зээлдэгчдийн тоо	5,997	5,904
6	"МИК актив зургаа ТЗК" ХХК	Гаргасан баталгаат үнэт цаасны дүн (тэрбум төгрөг)	261.7	261.7
		Зээлдэгчдийн тоо	5,227	5,244
7	"МИК актив долоо ТЗК" ХХК	Гаргасан баталгаат үнэт цаасны дүн (тэрбум төгрөг)	293.9	293.9
		Зээлдэгчдийн тоо	5,500	5,450
	Нийт	Нийт гаргасан баталгаат үнэт цаасны дүн (тэрбум төгрөг)	2,171.7	2,011.5
		Зээлдэгчдийн тоо	47,495	45,358

3.6. ХӨДӨӨ АЖ АХҮЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН АРИЛЖАА

"Хөдөө аж ахуйн бирж" ХХК нь 2015 онд шууд арилжих спот гэрээгээр бараа, түүхий эдийн арилжааг явуулсан ба 6,877.0 тонн ноолуур, 10,170.8 тонн хониндын ноос, 433.9 тонн тэмээнийн ноос, 1,411.8 тонн ямааны завод ноос, 719.0 тонн завод ноос, 1,576.0 тонн хүнсний буудайг нийт 431.7 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

Хөдөө аж ахуйн биржээр арилжаалгадсан бараа түүхий эдийн тус бүрийн үнийн дүнг өмнөх онуудын мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна:

Дурслэл 22. ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн арилжаа 2013–2015 он (тэрбум төгрөг)



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад, биржийн арилжааны дүн 22.0 хувиар буурсан байх ба үүнд түүхий эдийн голлох бараа болох ноолуурын чанараас шалтгаалсан зах зээлийн ханшийн уналт нөлөөлсөн байна.

2015 оны хавраас хүнсний буудайг биржээр арилжаалж эхэлсэн ба Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 4.10-д “Энэ хуулийн 4.5, 5.1.7-д заасан жагсаалтад орсон бараа, түүхий эдийг төсвийн

хөрөнгөөр худалдан авах бол биржээр дамжуулна” гэж заасны дагуу төсвийн хөрөнгөөр улаан буудай худалдан авалт хийх тохиолдолд биржээр дамжуулснаар арилжааны хэмжээнд эерэг нөлөө үзүүлнэ гэсэн хүлээлт байна. Цаашид арилжааны хэмжээ, хөрөнгөөр чадварыг нэмэгдүүлэх биржээр арилжаалагдах бараа, түүхий эдийн төрлийг олшуулах, стандартчилагдсан гэрээний арилжааг хөгжүүлэх шаардлагатай.

3.7. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Засгийн газрын 100 хувийн хөрөнгө оруулалт бүхий Зээлийн батлан даалтын сан (ЗБДС) 2012 онд үүсгэн байгуулагдаж, улмаар 2013 оны 5 дугаар сараас батлан даалтын үйл ажиллагаагаа эхлүүлж байсан.

Тус сан нь нийт 409 аж ахуйн нэгж, байгууллага, иргэний 75.3 тэрбум төгрөгийн зээлэнд 30.7 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан бөгөөд тайлант хугацаанд уг сангаас

гаргасан батлан даалтын дээд хэмжээ 499.0 сая төгрөг, доод хэмжээ 600.0 мянган төгрөг байв.

ЗБДС нь нийт 12 банк, 8 ББСБ, 1 ХЗХ-той хамтран ажиллас гэрээ байгуулснаас 9 банкаар дамжуулан батлан даалтын үйлчилгээг хүргэжээ.

Хүснэгт 5. Батлан даалт гаргасан байдал

№	Банк, санхүүгийн байгууллага	Батлан даалтын тоо	Батлан даалттай зээлийн хэмжээ (төгрөг)	Батлан даалтын хэмжээ (төгрөг)	Батлан даалтад эзлэх хувь	Хувийн жин
1	Голомт банк	101	20,746,010,000.00	8,641,017,000.00	28.09%	24.7%
2	Капитал банк	51	7,074,100,000.00	2,812,238,200.00	9.14%	12.5%
3	Төрийн банк	74	10,021,200,000.00	3,555,865,000.00	11.56%	18.1%
4	ХААН банк	62	15,370,289,470.00	6,398,740,545.00	20.80%	15.2%
5	Хас банк	85	9,462,000,000.00	4,358,689,500.00	14.17%	20.8%
6	Худалдаа хөгжлийн банк	33	12,314,600,000.00	4,789,981,800.00	15.57%	8.1%
7	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	1	140,000,000.00	80,880,800.00	0.26%	0.2%
8	Капитрон банк	1	20,000,000.00	3,100,000.00	0.01%	0.2%
9	Ариг Банк	1	200,000,000.00	120,000,000.00	0.39%	0.2%
Нийт		409	75,348,199,470.00	30,760,512,845.00	100.00%	100.0%

Эх сурвалж: Зээлийн батлан даалтын сан

2015 онд батлан даалт гаргахаар шийдвэрлэсэн зээлийн тоо өмнөх оноос 64.7 хувиар, батлан даалтын дүн нь 41.7 хувиар тус тус буурсан бөгөөд энэ нь банкуудын зээлийн хязгаарлалт болон төсөл хөтөлбөрийн зээл олголтын хэмжээ буурсантай шууд холбоотой.

Батлан даалтын үйлчилгээний хүртээмжийн хувьд нийт батлан даалтын 64.8 хувь нь Улаанбаатар хотод гаргасан батлан даалт, 35.2 хувь нь орон нутгийн зээлд гаргасан батлан даалт эзлэж байгаа ба нийт гаргасан батлан даалтын 5 хувь нь Өвөрхангай, 4 хувь нь Сэлэнгэ, 4 хувь нь Ховд аймагт тус тус гаргасан байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2015

Хүснэгт 6. Батлан даалтын хүртээмж

№	Үзүүлэлтүүд	Батлан даалтын тоо	Батлан даалтын дүн (төгрөг)	Батлан даалттай зээлийн дүн (төгрөг)	Хувь
1	Орон нутаг	144	6,65,711,200	13,467,950,000	35.2 %
2	Улаанбаатар	265	24,103,801,645	55,108,049,470	64.8 %
	Нийт	409	30,760,512,845	75,348,199,470	100 %

Эх сурвалж: Зээлийн батлан даалтын сан

Нийт батлан даалтын 23.3 хувь нь УХААЯ-ны төсөл, 28.9 хувь нь банкны, 24.5 хувь нь ЖДҮХС-ын төсөл, 23.3 хувь нь бусад эх үүсвэртэй зээл олголтод гаргасан байна.

Хүснэгт 7. Батлан даалтын эх үүсвэр

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Батлан даалтын тоо	Батлан даалтын дүн (төгрөг)	Батлан даалттай зээлийн дүн (төгрөг)	Батлан даалтад эзлэх хувь
1	Өрхийн бичил үйлдвэрлэлийг дэмжих сан	3	37,200,000.00	74,000,000.00	0.12%
2	Банк	139	8,640,932,945.00	20,565,089,470.00	28.09%
3	БХБЯ-ны төсөл	1	250,000,000.00	1,000,000,000.00	0.81%
4	ЖАЙКА	33	4,365,018,800.00	10,028,800,000.00	14.19%
5	ЖДҮХС-ын төсөл	92	7,537,916,700.00	18,362,300,000.00	24.51%
6	УХААЯ-ны төсөл	67	7,183,375,000.00	18,487,810,000.00	23.35%
7	ХЭДС	50	140,485,000.00	268,600,000.00	0.46%
8	Монгол 888 төсөл	11	1,572,389,000.00	3,632,600,000.00	5.11%
9	НЖДҮХС	9	412,195,400.00	769,000,000.00	1.34%
10	АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээл	2	21,000,000.00	60,000,000.00	0.07%
11	АҮЯ-ны арьс ширний төсөл	1	360,000,000.00	1,500,000,000.00	1.17%
12	АҮЯ-ны ноолуурын үйлдвэрийг дэмжих төсөл	1	240,000,000.00	600,000,000.00	0.78%
	Нийт	409	30,760,512,845.00	75,348,199,470.00	100.00%

Эх сурвалж: Зээлийн батлан даалтын сан

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАРЫН ХЯНАЛТ, БҮРТГЭЛ

4.1. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

Хорооны зохицуулалтын хүрээнд хамарагдах хуулийн этгээдийн санхүү, төлбөрийн чадвар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтэд зайны болон газар дээрх хяналт, шалгалтыг хийж, хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагаас баталсан журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээ авах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр хүлээсэн үүргээ тухай бүр хэрэгжүүлэн ажиллалаа.

ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫГ НЭВТРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ болох хөрөнгө оруулалтын сан, кастодианы үйлчилгээний хяналт, зохицуулалтын орчинг тодорхой болгох, ялангуяа хяналт, шалгалтын үр дүнг дээшлүүлэх, эрсдэлийг тооцоолох, хянах боломжийг бий болгох чиглэлээр нягтлан бодох бүртгэлийн суурь орчныг бүрдүүлэх зорилгоор “Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэлийн журам”, “Кастодианы үйлчилгээний нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг батлуулан, журмын дагуу тайлан, мэдээг хүлээн авч байна.

Түүнчлэн, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан “Маягт, заавар батлах тухай” 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 103/131 дүгээр тушаалаар Үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жишиг жагсаалт, санхүүгийн тайлан болон түүний тодруулгын маятыг батлуулж, журмын дагуу санхүүгийн тайланг хүлээн авч эхэллээ.

Зохицуулалттай этгээд, тусгай зөвшөөрөл эзэмшигч, үнэт цаас гаргагчдын үйл ажиллагаанд зайнаас тавих хяналтын хялбаршуулсан загвар гаргаж, хэрэгжүүлэх, хяналт, шалгалтын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам, зааварт өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах, үнэт цаасны зохицуулалттай этгээд, тусгай зөвшөөрөл эзэмшигч, үнэт цаас гаргагчийг шалгах хяналт, шалгалтын арга, аргачлалыг боловсронгуй болгох чиглэлээр хяналт, шалгалах хийж гарын авлага, зааварчилгаа бүхий баримт бичиг болох “Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдын газар дээрх хяналт шалгалтын журам”, “Бичил санхүүгийн байгууллагын хяналт шалгалтын гарын авлага”-ыг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллалаа.

Мөн “Хувьцаат компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлыг газар дээр нь шалгаж, үнэлэх журам”-ын төслийг боловсруулсны зэрэгцээ даатгалын компанийн эрсдэлд сууриссан хяналт шалгалтыг нэвтрүүлэх чиглэлээр гарын авлага боловсруулж, даатгалын компаниудад “Өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээ (ORSA)”-ний аргачлалыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

ЗАЙНААС ТАВИХ ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

ҮНЭТ ЦААС

Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч үнэт цаасны компани, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-д брокерийн үйлчилгээ үзүүлэгч этгээдийн санхүүгийн тайланг FinA системээр хүлээн авч тайлангийн хариуг хүргүүлэн ажиллалаа.

“Миллениум Ай Ти систем”-ийн “Миллениум сурвейланс” програмыг ашиглан ХК-ийн үнэт цаасны арилжаанд өдөр бүр хяналт тавин ажиллалаа.

Тайлант хугацаанд Хороонд 145 хувьцаат компани хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлээ ирүүлж, 133 компани хурлаа хуралдуулж, 173 компани санхүүгийн тайлангаа ирүүлж, олон нийтэд мэдээлжээ. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, баримт бичгийг хянаж, холбогдох хариуг албан тоотоор хүргүүллээ.

Нийт 23 хувьцаат компани нийт 199,854,730 ширхэг хувьцаанд ногдох 7.3 тэрбум төгрөгийн ногдол ашгийг тараахаар шийдвэрлэнээс “ҮЦТТТХТ” ХХК-аар дамжуулан 18 компани 30,367 харилцагчийн дансанд 403.9 сая төгрөгийн ногдол ашгийг байршуулан тараасан байна.

ДААТГАЛ

Тайлант хугацаанд даатгалын зохицуулалтын 78 байгууллагад зайны хяналт тавих явцад Хорооны зөвшөөрөлгүйгээр бүтээгдэхүүн борлуулсан, санхүүгийн тайлангийн хугацаа хоцроож ирүүлсэн, аудитлагдсан санхүүгийн тайланг олон нийтэд мэдээлээгүй, төлбөрийн чадварын үзүүлэлт хангаагүй, тогтвортой үйл ажиллагаа явуулаагүй, зөрүүтэй тайлан ирүүлсэн зэрэг нийтлэг зөрчлийг илрүүлж, нийт 8.5 сая төгрөгийн торгууль ногдууллаа.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2015

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ББСБ, ХЗХ-дын үйл ажиллагааны зохицтой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг FinA системээр хүлээн авч, тайлангийн хариуг тухай бүр хүргүүлж ажиллалаа.

Зээлийн мэдээллийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд ББСБ, ХЗХ-дыг Монголбанкны Зээлийн мэдээллийн сантай хамtran ажиллах гэрээ байгуулан ажиллах, гэрээний хуулбарыг Хороонд ирүүлэхийг үүрэг болгож, Хорооны цахим хуудсаас Зээлийн мэдээллийн санд өгөгдөл дамжуулах "MicroFinance" програмыг гарын авлагын дагуу үнэ төлбөрүүгээр суулган ашиглахыг зөвлөн ажиллалаа.

ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

ҮНЭТ ЦААС

Хувьцаа эзэмшигчдийн гаргасан өргөдлийн дагуу "Гутал" ХК, "УИД" ХК-ийн үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг хийж гүйцэтгэв. Мөн "Хөдөө аж ахуйн бирж" ХХК, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт хийж гүйцэтгэн, шалгалтын тайланг Хорооны хуралдаанаар танилцуулж, хугацаатай үүрэг даалгавар өглөө. Монголбанктай хамтарч үнэт цаасны төлбөр гүйцэтгэгч банкны үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хийж, гүйцэтглээ.

ДААТГАЛ

Хорооны даргын баталсан шалгалтын удирдамжийн дагуу 10 даатгалын компанийд 2013, 2014 оны даатгалын нөөцийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын үйл ажиллагаа, Даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан заалтын хэрэгжилтийн байдалд газар дээрх хэсэгчилсэн шалгалтыг хийж, гүйцэтглээ.

Шалгалттай холбогдуулан "Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай" Хорооны даргын 2015 оны 64 тоот тушаал гарч шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг ирүүлэх хугацаатай үүрэг өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

4.2. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ, ЭРХ ОЛГОХ, БҮРТГЭХ

Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн хүрээнд нийт 1,314 хуулийн этгээд, 632 салбар, төлөөлөгчийн газар, 4,731 иргэн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

2015 онд нийт 472 хуулийн этгээдэд шинээр тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй зохицуулалттай байгууллагуудад 36 тусгай зөвшөөрлийг нэмж олгосон ба 23 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан байна. Мөн 144 зохицуулалттай байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах, 66 салбар, төлөөлөгчийн газрыг шинээр байгуулах, 7 зохицуулалттай байгууллагын оноосон нэрийг өөрчлөх зөвшөөрлийг олгосон.

Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох, бүртгэлийн үйл ажиллагаанд цахим үйлчилгээний оновчтой тогтолцоог

Хорооны 2011 оны 337 дугаар тогтоолоор батлагдсан "Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам"-д заасны дагуу Албан журмын даатгагчдын холбоонд иж бүрэн шалгалт хийлээ.

Холбогдох хууль тогтоомж, журам, заавраар тавигдсан шаардлагыг хангаж ажиллаж байгаа эсэх, үйл ажиллагаанд нөлөөлж болох аливаа зөрчлийг илрүүлж, ирээдүйд учирч болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн тайлан, мэдээллийн үнэн зөв, бодитой эсэхэд хяналт тавьж, хөрөнгийн хүрэлцээ, төлбөрийн чадварыг хангуулж ажиллуулж байгаа эсэхийг шалгах зорилгоор 7 даатгалын компанийд газар дээрх иж бүрэн шалгалтыг хийж, гүйцэтглээ.

Мөн 2015 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөс 24-ний өдрүүдэд 2014 оны даатгалын байгууллагуудад аудит хийсэн нэр бүхий 15 аудитын компанийд газар дээрх чанарын хяналт, шалгалтыг Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамtran гүйцэтгэв.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Хорооны даргын баталсан шалгалтын удирдамжийн дагуу 3 ХЗХ, 5 ББСБ-уудад газар дээрх иж бүрэн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн бол Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй нэр бүхий 30 ББСБ-д газар дээрх үзлэг шалгалтыг хийлээ. Мөн нэр бүхий 28 ХЗХ-ны үйл ажиллагаанд хэсэгчилсэн шалгалтыг хийж, гүйцэтгэв.

Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаанд газар дээрх иж бүрэн шалгалтыг хийж, шалгалтын тайлангаар үүрэг өгч, биелэлтийг хангуулж ажилласан.

2015 онд улсын байцаагчдаас нэр бүхий 2 ХЗХ-нд 2.8 сая төгрөгийн, 2 ББСБ-д 7.7 сая төгрөгийн, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд 1 компанийд 9.6 сая төгрөгийн, нийт 20.1 сая төгрөгийн захиргааны хариуцлага ногдуулж, бүрэн төлүүлэв.

бий болгож, бүртгэл мэдээллийн нэгдсэн програм хангамжийг боловсруулан нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий газар, Авто тээврийн үндэсний төв, Үндэсний татварын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Цагдаагийн ерөнхий газар, Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар зэрэг төрийн бусад байгууллагуудтай мэдээлэл харилцан солилцох, хамtran ажиллах талаар гэрээ байгуулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгоход цаг алдалгүй, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэх чиглэлээр "Нэг цонхны үйлчилгээ"-г нэвтрүүлсэн бөгөөд иргэн, хуулийн этгээдэд холбогдох зөвлөгөөг тухай бүр өгч, баримт бичгийн бүрдлийг түргэн шуурхай хянах нөхцөлийг бүрдүүлсэн.

ТАВ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

ДЭЭД ГАЗРЫН ТОГТООЛ ШИЙДВЭР, ЖИЛИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хороо 2015 онд нийт 10 зүйлээр 128 ажил хийж гүйцэтгэн, 131 хүний бүрэлдэхүүнтэй, 2,910.8 сая төгрөгийн төсөвтэй ажиллахаар төлөвлөсөн.

2015 онд эрх бүхий байгууллагаас баталсан нийт 14 шийдвэрт хамаарах 73 заалтын биелэлтийг 2 удаагийн давтамжтайгаар гарган Улсын Их Хурал, Засгийн газар, холбогдох газруудад хүргүүллээ. Мөн 2013-2015 онуудад Улсын Их Хурлаас гарсан шийдвэр, салбарын хуулийн хэрэгжилт, хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн Улсын Их Хурлын Тамгын газарт тухай бүр хүргүүлсэн.

ХОРООНЫ ХУРАЛДААН, АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ

2015 онд Хорооны 30 удаагийн хуралдаанаас нийт 445 тогтоол, 16 тэмдэглэл гарсан ба Хорооны цахим хуудсаар олон нийтэд мэдээлж, биелэлтэд тухай бүр хяналт тавьж ажиллалаа. Хорооны даргын 375 тушаал, Ажлын албаны даргын 261 тушаал гарснаас, зохицуулалтын байгууллагатай холбоотой 280 тушаал, дотоод үйл ажиллагаатай холбоотой 356 тушаал гарсан байна

Хороо албан хэрэг бүртгэлийн “Бүтээмж-2014” програм ашигладаг бөгөөд 2015 онд нийт 10,017 албан бичиг, 481 өргөдөл, гомдлыг хүлээн авч, хуулийн хугацаанд хянан шийдвэрлэлээ. Мөн Хорооноос нийт 5,319 албан бичгийн холбогдох иргэн, хуулийн этгээдэд хүргүүлсэн.

5.2. ХАМТЫН АЖИЛЛАГАА

2015 оны жилийн эцсийн байдлаар харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд олон улсын болон гадаад орны зохицуулагч 7, Монгол Улсын төрийн 10, зохицуулалтын салбарын мэргэжлийн холбоо 10, төрийн бус 8, хэвлэл мэдээллийн 2, нийт 37 байгууллагатай хамтран ажиллаж байна.

Төрийн өмчит хувьцаат компаниудын хувьчлалыг идэвхижүүлэх, олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлдэг компаниудын засаглалыг сайжруулах ажлын хүрээнд Олон улсын санхүүгийн корпорацийн санхүүжилтээр “Жилийн тайлангийн олон улсын стандартыг нэвтрүүлэх төсөл”-ийг Компанийн засаглалын хөгжлийн төв, Төрийн өмчийн хороотой хамтран хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 124 дүгээр захирамжаар батлагдсан “Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг явуулах удирдамж”-ийн дагуу үзлэгт хамрагдан “А” үнэлгээ авлаа.

ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Оны эцсийн байдлаар Ажлын албаны нийт 126 албан хаагчдын 113 нь төрийн жинхэнэ албан хаагч, үүнээс төрийн захирагааны албан тушаалын зэрэг дэвтэй 49, үйлчилгээний албан хаагч 13 байна. Улсын байцаагчийн эрхтэй нийт 47 албан хаагч ажиллаж байгаагас Улсын ерөнхий байцаагч 1, улсын ахлах байцаагч 7, улсын байцаагч 39 байна.

“Хөдөлмөрийн дотоод журам”, “Архивын үйл ажиллагааны журам”, “Хорооны хуралдааны дэг”, “Үйл ажиллагаанд хамаарах нууцын журам”, “Байгууллагын архивын журам”, “Баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрэм”, “Хорооны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах болон Хорооны албан хаагчдын сургалтын хөтөлбөр” зэрэг байгууллагын дотоод дүрэм, журам, хөтөлбөрүүдээ шинэчлэн батлуулж, ажиллалаа.

Хорооноос өгсөн чиглэлийн дагуу зохицуулалтын байгууллагуудад үзлэг хяналт шалгалаат хийх үүрэг бүхий Хорооны 63 төлөөлөгчид нийслэлийн 9 дүүрэг, 21 аймагт ажиллав.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газрын “Санхүүгийн салбарын чадавхийг бэхжүүлэх сургалтын төсөл”, Азийн Хөгжлийн Банкны дэмжлэг, Ядуурлыг бууруулах Японы сангийн санхүүжилтээр “Эмзэг бүлгийн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”, Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны агентлагийн “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл”, ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгмэлэгийн “Бага, дунд орлоготой иргэдэд зориулсан даатгалын зах зээлийн зохицуулалтыг сайжруулах зорилго бүхий бус нутгийн хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлж байна.

Мөн Дэлхийн банкны “Олон салбарыг хамарсан техник туслалцааны (MSTAR) төсөл”-ийн хүрээнд “Монголын

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2015

Хөрөнгийн зах зээлийг 2020 он хүртэл хэрэгжүүлэх стратеги", "Цахим бүртгэл", "Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг боловсруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

Жил бүр уламжлал болгон зохиогддог "Монголын хөрөнгө оруулалтын дээд хэмжээний уулзалт"-д илтгэл тавьж, Хонконгийн Үнэт цаас, фьючерсийн хороо болон Хөрөнгийн биржийн удирдлагуудтай ажил хэргийн уулзалтыг хийлээ. Уулзалтын үр дүнд Хонконгийн Үнэт цаас, фьючерсийн хороотой дүрэм, журам болон хяналт шалгалтын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тогтоо.

БНСУ-ын Үнэт цаасны санхүүжилтийн корпорацитай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан энэ

хүрээнд харилцан мэдээлэл солилцох, үнэт цаасны зах зээлд санхүүжилт, хөрөнгө оруулалтыг сайжруулах талдээр хамтран ажиллав.

Лондонгийн хөрөнгийн бирж груп, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Япон Улсын Санхүүгийн үйлчилгээний агентлаг, Тайванийн Санхүүгийн хяналтын хороо, Австрали улсын Үнэт цаасны хороо зэрэг байгууллагуудын төлөөлөгчидтэй уулзаж, хамтын ажиллагааны талаар тодорхой шийдвэрдээ хүрлээ. Тухайлбал, Лондонгийн хөрөнгийн бирж груптэй "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн арилжааг идэвхижүүлэх, Европын сэргээн босголт, хөгжлийн банктай хөрөнгийн зах зээл, даатгалын салбарыг хөгжүүлэх, Австрали, Тайвань, Хонконгийн зохицуулагч байгууллагуудтай Хорооны зохицуулалтын чадавхийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцлоо.

5.3. ТӨСӨВ, САНХҮҮ

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

Хороо Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 20.1 дэх хэсэгт заасны дагуу улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө, тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлс, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулснаар олсон бусад орлогоор тус тус санхүүжилтээ бүрдүүлж ажиллалаа.

Тайлант онд тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс зохицуулалтын үйлчилгээний хөлс болох 1,018.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээс 49.4 хувийг даатгалын байгууллага, 31.4 хувийг ББСБ, 16.2 хувийг үнэт цаасны зохицуулалтын байгууллага, 2.9 хувийг ХЭХ, бусад орлого тус тус төвлөрүүлж, төсвийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, ажиллалаа.

Мөн улсын төсөвт 74.5 сая төгрөгийн тэмдэгтийн хураамж, 105.8 сая төгрөгийн торгуулийн орлогыг төвлөрүүлэн улсын төсөвт шилжүүлсэн.

ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тайлант онд Хорооны төсөв 3,054.9 сая төгрөг батлагдсанаас 2,719.9 сая төгрөгийг зарцуулж, 335.0 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллажээ.

Хорооны 2015 оны төсвийг зардлын бүтцээр нь авч үзэхэд нийт зардлын 59.5 хувийг цалин хөлс, 6.7 хувийг нийгмийн даатгал, 11.5 хувийг бараа үйлчилгээ, 7.0 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ, 6.1 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 9.2 хувийг татаас ба бусад шилжүүлэгт тус тус зарцуулсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, санхүүгийн тайлан тэнцэл гаргалт, тушаалт болон анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт, бүртгэлийн програм хангамж нэвтрүүлэлтэд тус тус 100.0 хувийн үзүүлэлттэйгээр байнгын болон байнгын бус өр, авлагагүйгээр ажиллав.

ЗУРГАА. 2015 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР

- Санхүүгийн үйлчилгээний тухай, Санхүүгийн хяналт, зохицуулалтын тухай, Санхүүгийн чөлөөт бүсийн тухай хуулийн төслүүдийг шинээр боловсруулан Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлсэн.
- Хөгжлийн банкны тухай, Аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдэд санал боловсруулж, холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлэв.
- Нийгмийн даатгалын тухай хуулийн төсөлд тэтгэврийн даатгалын сангийн үлдэгдэл хөрөнгөөр Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдан авах тухай нэмэлт өөрчлөлтийн талаар болон хувьцаа, компанийн бондод хөрөнгө оруулалт хийх боломжийг бий болгох чиглэлээр нэмэлт оруулах, сангийн хөрөнгийн удирдлагыг хөрөнгө оруулалтын менежментийн компаниар удирдуулах талаар саналыг тус тус хүргүүлж ажиллалаа.

ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР

- “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төслийг Монголбанк, Сангийн яамтай хамтран боловсруулан Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэв.
- Хороо, Сангийн яам, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн идэвхитэй хамтын ажиллагааны үр дүнд Хөрөнгийн биржээр арилжаалагдсан Засгийн газрын үнэт цаасны арилжааны хэмжээ 2014 онд 36.1 тэрбум төгрөг байсан бол 2015 онд 400.0 гаруй тэрбум төгрөгт хүрч нэмэгдэв.
- Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс төрийн өмчтэй 8 хувьцаат компанийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах тухай ажлын төлөвлөгөөг боловсруулан мөрдөж ажиллав.
- Кастодиан банкуудын үйл ажиллагааг эхлүүлэх ажлыг эрчимжүүлэх, үүнтэй холбогдуулан Хороо болон дэд бүтцийн бусад байгууллагууд хоорондын ажлын уялдааг хангах чиглэлээр “Милленниум Ай Ти систем” дээр кастодиан банкны номинал дансыг нээх, оролцогчдын хооронд мэдээлэл солилцох туршилтыг зохион байгуулав.
- Нийт 5 салбарын орон тооны бус бодлогын зөвлөлийг зах зээлд оролцогчдын бүрэлдэхүүнтэй байгуулж, зах зээлийн мэргэжилтнүүд, эрдэмтэн, судлаачдын саналыг хүлээн авч хэрэгжүүлэх тогтолцоог бий болгов.
- Монгол Улсад анхны хувийн хөрөнгө оруулалтын сан байгуулагдаж, үйл ажиллагаагаа эхлүүлэв.
- Даатгалын компанийн нөөц сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын санд байршуулах боломжийг нэмэгдүүлж, банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах хэмжээг 5.0 хүртэл хувь байсныг 20.0 хувь болгон нэмэгдүүлэв.
- “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХХК-д давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосноор давхар даатгалын хураамжийн гадагшлах урсгалыг багасгах боломжийг бүрдүүлэв.
- Даатгалын хүртээмж, иргэдийн даатгалд хамрагдах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор бага, дунд орлоготой иргэдэд зориулсан хөнгөвчилсөн нөхцөл бүхий гэр, хашаа, байшин, гэнэтийн ослын даатгалын 2 бүтээгдэхүүнийг шинэчлэн бүртгэж, зөвшөөрөл олгов.
- Жолоочийн даатгалын наалт бүхий баталгааг цахим хэлбэрт оруулнаар даатгуулагчийн мэдээлэл цахим хэлбэрээр хадгалагдаж, даатгалын гэрээ байгуулах үйл ажиллагаа даатгагч, даатгуулагчийн аль алинд хялбар болох нөхцөл бүрдэв.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР

- Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд болох эдийн засгийн өсөлт, инфляци, мөнгөний нийлүүлэлтийн чанаргүй зээлд үзүүлэх нөлөөллийг эконометриксийн аргад тулгуурлан боловсруулан банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоодын эрсдэлийн судалгааг хийж, гүйцэтгэв.
- Салбарын хэмжээнд эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор зайны хянaltaар банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2015

хоршоодын эрсдэлийн түвшинг зээлийн чанар, зээлийн хуримтлагдсан хүүгийн авлага, зардал төлдөг эх үүсвэр зээлийн харьцаа, активын өсөлт бууралт, ашигт ажиллагаа зэрэг үзүүлэлтээр тооцож, онцгой хяналт тавьж, ажиллах байгууллагуудыг тогтоов.

- Азийн Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлж байгаа "Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх" төслийн хүрээнд орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хадгаламж, зээлийн хоршоодын албан хэрэгцээнд нь зориулсан зөөврийн компьютер хүлээлгэн өгч нийт хадгаламж, зээлийн хоршоодыг удирдлагын мэдээллийн нэгдсэн системд холбох арга хэмжээг авч хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэлийн програмыг хүлээлгэн өгөв.
- Даатгалын болон үнэт цаасны компаниудад эрсдэлд суурилсан хяналт шалгалтын арга хэрэгслийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, холбогдох журам, зааврыг боловсронгуй болгох, FinA системд тоон мэдээлэл оруулах ажлууд хийгдэв. банк бус санхүүгийн байгуулага, хадгаламж, зээлийн

хоршоодын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын гарын авлагыг боловсруулж, мөрдөж эхлэв.

- Даатгалын компанийд мөрдөгдөх "Нягтлан бодох бүртгэлийн заавар"-ыг нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлж, шинэчлэн батлав.
- Мэдээллийн нэгдсэн сангийн түр журмыг баталж, зохицуулалттай салбарын мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэв.
- Бичил бизнесийг дэмжих хөтөлбөрийг хадгаламж, зээлийн хоршоодоор дамжуулахаар Хорооны дарга, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хооронд "Хамтын ажиллагааны санамж бичиг"-ийг байгуулж, Хорооноос нийт 114 хадгаламж, зээлийн хоршоонд төсөл, хөтөлбөр дамжуулан хэрэгжүүлэх зөвшөөрөл олгосноор, Нийслэлийн 130 хорооны 101 хадгаламж, зээлийн хоршоодоор дамжуулж, 10.6 тэрбум төгрөгийг жилийн 14.4 хүртэл хүйтэйгээр 2,712 бичил бизнесийн төсөлд олгуулж, 7,600 ажлын байрыг бий болгов.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ДААТГУУЛАГЧ, ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР

- Хяналт шалгалтын газарт ирж буй өргөдөл, гомдолд сар, улирал тутам дун шинжилгээ, судалгааг хийж, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлж буй өргөдөл, гомдлын мэдээллийг Хорооны цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлж, ажиллав.
- Үнэт цаасны салбарын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мереөр 9.2 сая төгрөгийн хохирлыг барагдуулав. Мөн даатгалын салбарт

иরүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мөрөөр 168.5 сая төгрөгийг даатгуулагчдад олгуулав.

- Автотээврийн хэрэгслийн даатгалын гэрээнд тусгагдсан даатгалын нөхөн төлбөр олгооос татгалзах нөхцөлийг Хорооны болон тухайн компанийн цахим хуудаст байршуулнаар даатгалын гэрээтэй холбоотой мэдээлэл ил тод болов.

ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- "Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр 2016-2021"-ийг Сангийн яам, Монголбанк, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамтай хамtran боловсруулан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлаар батлуулж, хөрөнгө оруулалт, даатгалын үйл ажиллагааны чиглэлээр тусгайлсан талбар бүхий үндэсний хэмжээний цахим хуудасны загварыг боловсруулав.
- Иргэн, хуулийн этгээдэд холбогдох зөвлөгөөг тухай бүр өгөх, баримт бичгийн бүрдлийг хянах "Нэг цонхны үйлчилгээ"-г нэвтрүүлснээр иргэд, хуулийн этгээдэд санхүүгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох, бүртгэх үйлчилгээг түргэн, шуурхай, ил тод, чирэгдэлгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн ба цахим үйлчилгээний оновчтой тогтолцоог бий болгож, бүртгэл мэдээллийн нэгдсэн програм хангамжийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, холбогдох төрийн байгууллагуудтай хамtran ажилласнаар бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд буй мэдээллийг цахим байдаа хүлээн авдаг болов.
- "Санхүүгийн үйлчилгээний хүртээмж ба орон нутгийн хөгжил" бус нутгийн чуулга уулзалтыг Завхан, Хэнтий аймгуудад тус тус зохион байгуулсан ба "Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он

хүртэл хөгжлүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн төслийг зах зээлд оролцогч, мэргэжлийн байгууллагуудад танилцуулах хэлэлцүүлэг, "Санхүүгийн зах зээлийн үндэсний анхдуугаар форум"-ыг тус тус зохион байгуулав.

- Зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдүүлэхээр шинээр болон шинэчлэн боловсруулсан журам, заавар, аргачлал, бусад эрх зүйн хэм хэмжээг мэргэжлийн холбоод, зохицуулалтын байгууллагуудад танилцуулах зорилгоор сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг тухай бүр зохион байгуулан ажиллав.
- Хорооноос гарч буй шийдвэр болон санхүүгийн зах зээлийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх ажлын хүрээнд олон нийтийн хэвлэл мэдээллийн 15 телевиз, 1 радио, 2 мэдээллийн агентлаг, 6 өдөр тутмын сонин, 1 сэтгүүл, 18 цахим хуудастай хамtran ажиллалаа. Мөн санхүүгийн зах зээлийн талаарх мэдээ, мэдээлэл бүхий "Mongolian Finance" сэтгүүлийн анхны дугаарыг эрхлэн гаргаж, олон нийтийн хүртээл болгов.
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn цахим хуудсанд санхүүгийн зах зээлийн мэдээллийн бүтэц агуулгыг шинэчлэв.

ДОЛОО. 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР

Нэгдсэн бодлого, зохицуулалтын чиглэлээр:

- “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төслийг эрх бүхий байгууллагад хүргүүлж, батлуулах;
- “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны 2016-2021 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг”-г боловсруулж, батлах;
- Зохицуулалтын хүрээний, санхүүгийн салбарын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдийг татварын бодлогоор дэмжих, хөрөнгө оруулагчийг ногдол ашиг, ханшийн зөрүүнээс олсон орлого, хадгаламж, зээлийн хоршоодын орлогыг орлогын албан татвараас чөлөөлөх чиглэлээр татварын багц хуульд өөрчлөлт оруулах саналыг боловсруулан Сангийн яамтай хамтран ажиллаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;
- Санхүүгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагаа болон салбарын системийн эрсдэлүүдийг тооцоолох;
- Хөрөнгө оруулагч, даатгуулагч, хэрэглэгчийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх.

Үнэт цаасны зах зээлийн чиглэлээр:

- Кастодианы үйлчилгээг үнэт цаасны зах зээлд нэвтрүүлэх, үйл ажиллагааг жигдриүүлэх;
- Давхар бүртгэл, хадгаламжийн бичиг болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн зохицуулалтын орчинг бий болгох;
- Үнэт цаасны төлбөр тооцоог дараа төлбөрт горимд шилжүүлэх;
- Бүртгэлийн шаардлага хангаагүй хувьцаат компанийг биржийн бүртгэлээс хасах, өрийн хэрэгслийг дэмжих чиглэлээр зохицуулалтын орчинг сайжруулах;
- Хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор үнэт цаасыг зээлээр худалдах, худалдан авах үйл ажиллагааг хөгжүүлэх, хувьцаат компаниудын мэдээлэл, тайлагналын тогтолцоог сайжруулах;
- Өөрийгөө зохицуулах байгууллагуудыг чадавхижуулж, төрийн зарим чиг үүргийг үе шаттайгаар шилжүүлэх.

Даатгалын салбарын чиглэлээр:

- Даатгалын шинэ хэлбэр, бүтээгдэхүүний гэрээний өөрчлөлтийн хяналт, үнийн зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Нийгмийн даатгалын зарим төрлийн үйлчилгээг хувийн амьдралын даатгалд шилжүүлэх, урт хугацааны болон хувийн тэтгэврийн даатгалын зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр Засгийн газартай хамтран ажиллах;
- Албан журмын даатгалын шинэ бүтээгдэхүүнийг дэмжих хууль эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр Сангийн яамтай хамтран ажиллах;
- Даатгалын зах зээлд давхар болон экспортын даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;
- Даатгалын андеррайтерийн үйлчилгээг идэвхижүүлэх, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг дэмжих хүртээмжтэй даатгалын үйлчилгээг хөгжүүлэх;
- Нийгмийн халамжийн зарлага, ипотекийн зээлийн зээлдэгчийн амь насны даатгалыг урт хугацаат даатгалын бүтээгдэхүүний хэлбэрт оруулах асуудлаар холбогдох төрийн байгууллагуудтай хамтарч ажиллах;
- Даатгалын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх.

Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж, зээлийн хоршооны чиглэлээр:

- Хадгаламж, зээлийн хоршооны тогтворталтын үйлчилгээ, тэдгээрийн гишүүдийн хадгаламжийг хадгаламжийн даатгалд хамруулах;
- Хөдөлмөрийн яам, Аж үйлдвэрийн яам, Бичил санхүүгийн хөгжлийн сан болон бусад эрх бүхий байгууллагуудаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоодыг хамруулах, нэмэлт санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр зохицуулалтын орчинг бүрдүүлэх;
- Зээлийн эрсдэлийг бууруулах замаар санхүүгийн зуучлалын үр ашигийг нэмэгдүүлэх зохицуулалтын орчинг бүрдүүлэх;

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2015

4. Актив удирдлагын тогтолцоог бий болгоход банк бус санхүүгийн байгууллагуудыг татан оролцуулах чиглэлээр Монголбанктай хамтран ажиллах.

Хяналт, шалгалт, бүртгэл, зөвшөөрлийн чиглэлээр:

1. Хорооны хяналт, зохицуулалтад хамаарах санхүүгийн салбаруудад чиглэгдсэн эрсдэлд сууриссан хяналт, шалгалтын гарын авлага боловсруулж, мөрдөж ажиллах;
2. Даатгалын компаниудад “Өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээ” (ORSA)-ний аргачлалыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах;
3. Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд хийх эрсдэлд сууриссан хяналт, шалгалттай холбоотой зохицуулалтыг холбогдох журам, зааварт тусгаж, батлах;
4. Үнэт цаасны зах зээлд оролцогч зохицуулалттай этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болох тохиолдолд авах арга хэмжээний тухай зохицуулалтын орчин бүрдүүлэх;

5. Зохицуулалттай этгээд, тусгай зөвшөөрөл эзэмшигч, үнэт цаас гаргагчдын үйл ажиллагааны зайны хяналтын загварыг боловсруулж, баталж, мөрдөх;
6. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл эзэмшигч иргэд, хуулийн этгээдийн нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх.

Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр:

1. “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр 2016-2021”-ийг төрийн холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;
2. “Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хөтөлбөр”-ийн төслийг боловсруулах;
3. Санхүүгийн зах зээлийн мэдээллийг олон нийтэд ил тод, шуурхай хүргэх.

Хавсралт 1

САНАМЖ БИЧГИЙН ХҮРЭЭНД ХАМТРАН АЖИЛЛАЖ БҮЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

№	САНАМЖ БИЧГ БАЙГУУЛСАН БАЙГУУЛЛАГЫН НЭР	ОГНОО
1. ГАДААД ОРНЫ ИЖИЛ ТӨСТЭЙ УЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ БАЙГУУЛЛАГУУД		
1	БНХАУ-ын Үнэт цаасны зохицуулах хороо	2008.01.24
2	БНСУ-ын Санхүүгийн хяналт шалгалтын алба	2010
3	Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газар	2008.10.27
4	БНПУ-ын Санхүүгийн хяналт шалгалтын байгууллага	2010.10.07
5	БНКУ-ын Санхүүгийн зах эээл, санхүүгийн байгууллагын зохицуулалт хяналтын агентлаг	2009.09.25
6	Хонконгийн үнэт цаас фьючерсийн хороо	2013.10.02
7	БНСУ-ын Үнэт цаасны санхүүжилтийн корпораци	2015
2. МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД		
8	Монголбанк, Сангийн яам	2006.11.10
9	Барилга, хот байгуулалтын яам	2006.03.17
10	Татварын ерөнхий газар	2012.11.30
11	Үндэсний статистикийн хороо	2010
12	Жижиг дунд үйлдвэрийн газар, Монголын даатгалын холбоо	2009.10.30
13	Төрийн өмчийн хороо	2013.11.17
14	Хүхэдийн төлөө үндэсний газар, Монголын даатгагчдын холбоо	2014.07.07
15	Нийслэлийн Засаг даргын тамгын газар	2015
16	Төрийн өмчийн хороо, Компанийн засаглалын үндэсний зөвлөл	2015
17	Шүүхийн ерөнхий зөвлөл	2015
3. ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАРЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБООД		
18	Монголын даатгагчдын холбоо	2010.02.26
19	Монголын актуарчдын нийгэмлэг	2010.05.05
20	Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо	2008.03.02
21	Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо	2008.03.02
22	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт	2009.10.22
23	Монголын мэргэшсэн үнэлгээчийн институт	2012.05.21
24	Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо	2014.06.10
25	ХАА-н биржийн зохицуулах зөвлөлийн ажлын алба, ХАА-н гаралтай бараа түүхий эд бэлтгэн нийлүүлэгч мэргэшсэн брокеруудын нэгдсэн холбоо	2014.05.08
26	Монголын албан журмын даатгагчдын холбоо	2014.05.26
27	Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо	2015
4. ТӨРИЙН БУС БОЛОН БУСАД БАЙГУУЛЛАГУУД		
28	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	2006.11.27
29	Хас банк	2006.11.03
30	Малын индексжуулсэн даатгалын төсөл хэрэгжүүлэх нэгж	2007.03.01
31	Санхүү, эдийн засгийн дээд сургууль	2009.03.06
32	Банк санхүүгийн академи	2015
33	Санхүү, эдийн засгийн дээд сургууль	2015
34	"Шударга ёсыг бадраах сан" ТББ	2015
35	Монголын хуульчдын холбоо	2015
5. ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГА		
36	"Монголиан экономи" сэтгүүл	2012.10.18
37	"Санхүүгийн лавлах мэдээ"сонин	2014.04.15

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ, ЭРХИЙН СУДАЛГАА

1. ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД		
№	Үйл ажиллагааны чиглэл	Байгууллагын тоо
1	Хувьцаат компани	299
2	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан компани	8
3	Даатгалын компани	17
4	Банк бус санхүүгийн байгууллага	450
5	Хадгаламж, зээлийн хоршоо	253
6	Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага ("Монголын хөрөнгийн бирж" ХК)	1
7	Үнэт цаасны арилжаа төлбөр, тооцоо, төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага ("ҮЦТТХТ" ХХК)	1
8	Үнэт цаасны арилжаа эрхлэх, үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа эрхлэх байгууллага ("Монголын үнэт цаасны бирж" ХХК)	1
9	Үнэт цаасны компани (БДК, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх)	62
10	Кастодиан банк	3
11	Хөрөнгө оруулалтын менежментийн компани	7
12	Хөрөнгө итгэмжлэн удирдах компани	1
13	Өөрийгөө зохицуулах байгууллага	2
14	Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх аудитын компани	36
15	Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх үнэлгээний компани	20
16	Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх хуулийн компани	17
17	Даатгалын байгууллагад аудит хийх эрхтэй байгууллага	35
18	Даатгалын хохирол үнэлэгч байгууллага	27
19	Даатгалын зуучлагч байгууллага	37
20	Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	37

2. ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР		
№	Үйл ажиллагааны чиглэл	Салбарын тоо
1	Үнэт цаасны зохицуулалттай этгээдийн салбар	23
2	Даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газар	255
3	Даатгалын хохирол үнэлэгч байгууллагын салбар	52
4	Даатгалын зуучлагч байгууллагын салбар	173
5	Банк бус санхүүгийн байгууллагын салбар, төлөөлөгчийн газар	121
6	Хадгаламж, зээлийн хоршооны салбар	8

3. МЭРГЭЖЛИЙН ЭРХ БҮХИЙ ИРГЭД		
№	Үйл ажиллагааны чиглэл	Иргэдийн тоо
1	Үнэт цаасны зах зээл дээр ажиллах мэргэжилтэн	1155
2	Даатгалын төлөөлөгч	3340
3	Даатгалын аудитор	221
4	Актуарч	15

Хавсралт 3

2015 ОНД БАТАЛСАН ЖУРАМ, ЗААВРЫН ЖАГСААЛТ

№		ЗОХИЦУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН НЭР	ТАЙЛБАР
1. БҮХ САЛБАРТ			
1	1	Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох, төвлөрүүлэх журам	Шинээр
2	2	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн баримт бичгийг хүлээн авах, хянах заавар	Шинээр
2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ			
3	1	Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны тухай журам	Шинээр
4	2	Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам	Шинээр
5	3	Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих тухай журам	Шинээр
6	4	Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, цэвэр хөрөнгө үнэлэх заавар	Шинээр
7	5	Кастодианы санхүүгийн тайлагнал бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх заавар	Шинээр
8	6	Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, цэвэр хөрөнгийг үнэлэх заавар	Шинээр
9	7	Үнэт цаасны бүртгэлийн журам	Шинэчлэн
10	8	Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны журам	Шинэчлэн
11	9	Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт нөхөх, баримт бичгийг бүрдүүлэх заавар	Шинэчлэн
12	10	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам	Нэмэлт, өөрчлөлт
13	11	Үнэт цаасны бүртгэлийн журам	Нэмэлт өөрчлөлт
14	12	Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам	Нэмэлт өөрчлөлт
15	13	Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам	Өөрчлөлт
3. ДААТГАЛЫН САЛБАРТ			
16	1	Албан журмын даатгагчдын холбооны санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам	Шинээр
17	2	Даатгагчийн болон даатгагчийн мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны зохицуулалтын журам	Шинээр
18	3	Малын индексжүүлсэн даатгалын хураамжийн хэмжээг тооцох журам	Шинээр
19	4	Малын индексжүүлсэн даатгалын хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх, зарцуулах журам	Шинээр
20	5	Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам, Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягтыг бэглэх, баримт бичгийг бүрдүүлэх заавар, Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн өргөдөл, зөвшөөрөл, бүртгэлийн хүсэлт, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар	Шинэчлэн
21	6	Албан журмын даатгагчдын холбооны шуурхай албаны ажиллах журам	Шинэчлэн
22	7	Жолоочийн даатгалын баталгааны загвар, хэрэглэх журам	Шинэчлэн
23	8	Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт үнэлгээ болон актуарчийн хяналт, шалгалт хийх, тайлан гаргах журам	Шинэчлэн
24	9	Нягтлан бодох бүртгэлийн заавар, Дансын жагсаалт, Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал	Шинэчлэн
25	10	Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам	Өөрчлөлт

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2015

26	11	Үрт хугацааны даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам	Өөрчлөлт
27	12	Үрт хугацааны даатгагчийн дурмийн сан болон нөөц сан хөрөнгөөс хөрөнгө оруулалт хийх хөрөнгийн хэмжээ, түүнд тавигдах шаардлага	Өөрчлөлт
28	13	Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээ тооцох итгэлцүүр хэрэглэх журам	Өөрчлөлт
29	14	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний даатгуулагчийн мэдүүлгийн маягт	Өөрчлөлт
30	15	Дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгсэлийн жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам	Өөрчлөлт
31	16	Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Нэмэлт өөрчлөлт
32	17	Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам	Нэмэлт өөрчлөлт
33	18	Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам	Өөрчлөлт
34	19	Ердийн даатгалын компанийн нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага	Өөрчлөлт
35	20	Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн журам	Нэмэлт өөрчлөлт
36	21	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний стандарт загвар	Нэмэлт өөрчлөлт
37	22	Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам	Хүчингүй болгосон
38	23	Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоos төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам	Хүчингүй болгосон
39	24	Гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа явуулах журам	Хүчингүй болгосон
40	25	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам	Хүчингүй болгосон
41	26	Үрт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх этээдэд тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хүчингүй болгосон
42	27	Гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх болон гадаад үйл ажиллагаа явуулах даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага	Хүчингүй болгосон
4. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО			
43	1	Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохицуулалтын журам	Шинээр
44	2	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам	Шинээр
45	3	Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт бөглөх, баримт бичгийг бүрдүүлэх заавар	Шинээр
46	4	Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар	Шинээр
47	5	Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт бөглөх, баримт бичгийг бүрдүүлэх заавар	Шинээр
48	6	Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар	Шинээр
49	7	Банк бус санхүүгийн байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	Шинээр
50	8	Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам	Шинэчлэн
51	9	Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам	Шинэчлэн
52	10	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам	Нэмэлт өөрчлөлт
53	11	Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон дагаж мөрдөх үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам	Нэмэлт өөрчлөлт
54	12	Хадгаламж, зээлийн хоршооноос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	Нэмэлт өөрчлөлт
55	13	Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний зохицуулалтын журам	Хүчингүй болгосон
56	14	Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд журам боловсруулах заавар	Хүчингүй болгосон

57	15	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам	Хүчингүй болгосон
58	16	Банк бус санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх журам	Хүчингүй болгосон
59	17	Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх журам	Хүчингүй болгосон
60	18	Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам	Хүчингүй болгосон
61	19	Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний журам	Хүчингүй болгосон
62	20	Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний жагсаалт батлах тухай	Хүчингүй болгосон
63	21	Банк бус санхүүгийн байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	Хүчингүй болгосон

--00--

